



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.10.15, МЯГМАР ~ №178 (1230)

~ МОНГОЛ ХҮН БҮР БАЯЖИГТУН ~


ҮНЭ: 1000Т

Чадвал муу хэвээрээ, чадахгүй бол шалдаа унаж, бүр шившиг болно УИХ дахь МАН-ын 65 гишүүн энэхүү алтан боломжоо алдах аваас тэдний хохь болно. > 2	Хөгжлийн бэрхшээлтэй 73.2 мянган иргэний 0.04 хувь нь л ажлын байртай болжээ > 4	FULL ENGLISH PAGE INSIDE > 7	Майкл Плат #205 \$8.0 тэрбум BlueCrest Capital Management-ийн үүсгэн байгуулагч, Английн тэрбумтан.
---	--	--	---

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Зэвсэгт хүчний 013 дугаар ангийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагналаа.
Минск болон Абу Даби хотод Монгол Улсын ЭСЯ-ыг нээхээр боллоо.
Д.Оюунхорол: Угаартаж амиа алдсан иргэдийн ар гэрт нөхөн төлбөр олгохыг хөөцөлдөнө.
НАМЭХ-ны тэргүүнд гурван гишүүн, нэг дэд сайд өрсөлдөж байна.

ЭДИЙН ЗАСАГ
Инфляцын түвшин есдүгээр сард есөн хувь болж, дөрвөн жилийн дээд цэгт хүрэв.
Улсын төсөв оны эхний өсөн сард 484.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.
Гадаад валютын нөөц наймдугаар сард 30 орчим хувиар өсөж, 3.6 тэрбум ам.доллартай тэнцсэн байна.
Топ 20 индекс 1.2 хувиар буурч, 18770.79 нэгжид хүрлээ.



НИЙГЭМ
Улсын хэмжээнд энэ оны эхний өсөн сард 58.1 мянган эх амаржиж, 58.5 мянган хүүхэд төрүүлжээ.
133 дугаар сургуулийг шинэ байртай болтол хүүхдүүдээ хичээлд нь явуулахгүй гэв.
2019 онд их, дээд сургууль төгсөгчдийн 58.5 хувь нь эмэгтэйчүүд байжээ.
СХД-т 53 мянган айл өрхөд сайжруулсан түлшний талаар зөвлөмж тараалаа.

ДЭЛХИЙ
Есдүгээр сард Хятадын экспорт, импортын хэмжээ таамгаас доогуур дүнтэй гарав.
БНСУ руу халдвартай гахай орж ирвэл устгах мэргэн буучдыг хил дээр байрлуулав.
Хүчирхийллийн үеэр Хонконгийн цагдаагийн ажилтны хүүзүүг мээсээр зүссэн хэрэг гарчээ.
ДХБ АНУ-ыг ЕХ-ны барааны импортод \$7.5 тэрбум хүртэл тариф ногдуулахыг зөвшөөрлөө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР


2019.10.15



10° | -6°

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮЭЭС УНШИНА УУ.

БАГАВТАР ҮҮЛТЭЙ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Итгэлийн зээлийн оронд ипотекийг санхүүжүүлбэл 5000 айл байртай болно



Улстөрчид барьцаагүй, эргэн төлөгдөх нь тодорхойгүй зээлд баруун солгойгүй мөнгө цацахаа амлаж байгаа атлаа Улаанбаатарын агаар, орчны бохирдолд цэг тавих ипотекийн зээлд илүүчлэх мөнгөгүй хэмээн мөрөө хавчиж байна. ► 3

ЦАГ ҮЕ

Азотын давхар исэл, хүхрийн нэгдэл утааны хорыг нэмэгдүүлж эхэллээ

Э.Батцэцэг
ЗГМ

Цаг уур, орчны шинжилгээний газраас аравдугаар сарын эхний долоо хоногийн агаарын найрлага дахь хорт бодисуудын хэмжээг шинжилсэн тайланд хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂) эрс ихсэж, хүлцэх хэмжээнээс өндөр болсныг харууллаа. Тодруулбал, нэг шоо метрт 50 микрограмм (мкг)-аар хүлцэх хэмжээг тогтоосон байхад хоногийн дундаж агууламж нь хүхэрлэг хий 102 мкг болж, азотын давхар исэл 86 мкг хүрсэн байна. Шахмал түлшийг гаднын

лабораториудад шинжлүүлэхээр явуулсан, чанарыг өвөл аяндаа шалгаад өгнө гэх мэтээр хугацаа хожих гэсэн нүүдэл эрх баригчдын зүгээс хийж байгаа. Гэвч хэмжигч төхөөрөмж агаар дахь бохирдуулагч бодисын агууламж нэмэгдэж буйг үзүүлсэн нь ямар ч дүгнэлтээс илүү ойлгомжтой болгож байна.

Хүхрийн хий болон азотын давхар исэл нь нүүрс шатах явцад үүсдэг химийн хорт нэгдлүүд бөгөөд сайжруулсан шахмал түлшнээс илүү их гарах магадлалтайг ШУА-ын ерөнхийлөгч Д.Рэгдэл баталлаа.

► 5

ДЭЛХИЙ

Трампын гар барилт эдийн засгийг сэргээх үү

Брендан Муррей

Хятад, АНУ хоёр өргөн хэмжээний худалдааны гэрээ байгуулах төлөвийг нээлттэй үлдээсэн боловч хоёр орны өсөлтийг дэмжих бодитой зүйл хийсэнгүй. Учир нь тэд эдийн засагчдын үл итгэдэг “Гар барилт” гэх зүйлээс цааш хэтэрсэнгүй. Хятадын тал Америкийн ХАА-н бүтээгдэхүүний худалдан авалтаа хоёр дахин өсгөж, жилдээ 50 тэрбум ам.долларт хүргэнэ хэмээн амлав. Энэ нь Дональд Трампыг 2020 онд дахин сонгогдоход тустай хөдөөгийн сонгогчдод хандсан улс төрийн алхам болохоос 21 их наяд

ам.долларын ДНБ-тэй улсын хувьд өчүүхэн хэмжээ юм. Хариуд нь Бээжин энэ сард төлөвлөгдсөн тарифын өсөлтийг хойшлуулах шийдвэрийг Цагаан ордноор гаргуулж чадлаа. Гэвч Трампын эдийн засгийн томоохон сүрдүүлэг болон хар үүл хэвээр үлдээд байна. Хятадаас ирэх импортын бүх бараанд ногдуулах тариф 12 дугаар сарын 15-нд хэрэгжих хэвээр байгаа нь өргөн хэрэглээний олон барааны үнийг өсгөнө.

► 9

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улс “Саарал жагсаалт”-д орох эсэхийг өнөөдөр шийднэ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM


Монголд ажил хөдөлмөр эрхэлж буй Хойд Солонгосын иргэдийг ирэх сараас өмнө нутаг буцаахаар болжээ. Хэрэв тэд энэ хэвээр ажилласаар байвал Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын шаардлагыг манай

улс биелүүлээгүй орны нэгт тооцогдох юм. Ингэснээр санхүүгийн хориг арга хэмжээнд өртөж, олон улсаас тусгаарлагдах, улмаар “Саарал жагсаалт” руу хөл тавихад хүрэх юм байна. Тиймээс урьдчилан сэргийлэх үүднээс дээрх арга хэмжээг даруй авч эхэлжээ. Хэдий тийм боловч Монголд ирж ажилласан олон улсын байгууллагынхан манай улсын

парламентын гишүүд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт нь маш сул байгааг шүүмжилсэн байна. Зөвхөн миний кредит картыг зарим оронд уншихгүй байна гэж УИХ-ын гишүүн гомдол мэдүүлсэн нь энэхүү дүгнэлт рүү залжээ.

► 12

ЗГМ: ИНФОГРАФИК



АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1,499.96 0.43%	5,722.00 1.40%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2667.70	373.19	40.96

Улс төр

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаа дуусгаж гэмээнэ сая хийсэн юмтай парламент байсан юм гэж бардам хэлж болно.



С.Батсайхан / ЗГМ©

Чадвал муу хэвээрээ, чадахгүй бол шалдаа унаж, бүр шившиг болно

УИХ дахь МАН-ын 65 гишүүн алтан боломжоо алдах аваас тэдний хохь болно

Ш.Алтай
ЗГМ

Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эхийг батлах тухай УИХ-аас гаргасан 73 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж, хоригийг УИХ хүлээж авснаас хойш нэг сар өнгөрлөө.

Хориг тавьсан гол шалтгаан нь: Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг хууль хэлбэрээр хэлэлцээгүй явдал гэж дурдсан байсан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна” гэж заасан байдаг ч энэ удаагийн тохиолдолд хоёрдмол утга харагдаад, нэг бодлын зөрчсөн ч юм шиг, нөгөө бодлын үгүй ч юм шиг. Гагцхүү хэрхэн яаж тайлбарлахаас л шалтгаалах асуудал харагдаад байдаг. Яагаад гэвэл хоёрдугаар хэлэлцүүлэг дуусан дуустал анхнаасаа л Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай “хуулийн төсөл” гэж хэлэлцсэн шүү дээ. Тэгээд ч энэ хоёрдмол утгатай заалтыг Ажлын хэсэг өнгөрсөн долоо хоногт залруулсан. Одоо цааш хэрхэх бол гэдэг нь анхаарал татах асуудал боллоо.

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах эс авах асуудлаар эрх баригч МАН-ынхан дотроо талцан нэлээд ширүүхэн юм болсныг уншигч авхай нар дуулсан байх. Тус намын Удирдах Зөвлөлөөс хүлээж авахгүй гэсэн шийдвэр гаргасан ч УИХ дахь бүлэг нь эсрэг шийдвэр гарган хүлээгээд авчихсан билээ. Ингэснээр Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн төслийн эхийг ард нийтээс асуух санал асуулга зохион байгуулагдах

шаардлагагүй болчихож байгаа юм.

Мөн хоёрдугаар хэлэлцүүлэгээр хийсэн нэмэлт өөрчлөлтийн төсөл задарч болзошгүй нь. Өөрөөр хэлбэл, хоёрдугаар хэлэлцүүлэг бүхэлдээ задрах аваас дахин эхнээс нь хэлэлцэнэ гэсэн үг. Гэтэл УИХ-д ийм боломж бололцоо, цаг хугацаа туйлын хомс. За бараг л амжихгүй болов уу. Яагаад гэвэл өнөө маргаашгүй төсвийн хуулийг хэлэлцэх шаардлагатай болно. Ингээд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг гацаанд орох болно. Хэрэв гацаанд оруулж, УИХ дахь МАН-ын 65 гишүүн магадгүй дахиад хэзээ ч олдохгүй энэ боломжоо хүнд ч биш, өөрт ч биш болгож гаргуундаа гаргахаар шийдэх аваас тэдэнд л туйлын харамсалтай хэрэг болох биз. Ингэсэн тохиолдолд ямар үр дагавар, дүр зураг харагдах бол оо! Мэдээж УИХ-ын нэр хүнд улам унана. Ерөөсөө ч унах нэр хүндгүй шахам болсон энэ парламент түүхэнд “хулгайч”, “луйварчин”, “ЖДҮ-чин” гэсэн хар шошготой үлдэх нь тодорхой.

Харин энэ олон жилийн турш хэд хэдэн парламентын хийх гээд

чадаагүй Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэсэн чанга “ажил”-ыг нугалж, хийж чадсан нөхдүүд шүү дээ гэсэн түүх цацгийг үлдээж болох алтан боломжоо алдах аваас үнэхээр тэдний хохь. Хамгийн арчаагүй, олонхын засаглал, хүчийг амталж чадаагүй “гар”-ууд гэсэн олхиогүй “чимэг” тэдэнд нэмэгдэнэ. Тэгээд энэ дөрвөн жилийн хугацаанд ард түмний төлөө, нийгмийн тусын тулд ямар юм хийлээ гэж тайлан тавих гэсэн юм бол. Тарна, тарахгүйдээ тулж баахан улстөржлөө. Тараагүйнхээ шалтгааныг тэгээд харуулах хэрэгтэй боллоо шүү дээ. Яаж ийж байгаад л Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаа дуусгаж гэмээнэ сая бид хийсэн юмтай парламент байсан юм гэж бардам хэлж болно. Яг үнэндээ хоёрдугаар хэлэлцүүлэгт багтсан өөрчлөлтүүд тийм муу өөрчлөлт биш билээ. Энд зүгээр цэвэр улс төрийн тоглолт болоод байгааг эрхэм гишүүд эрх биш гадарладаг байлгүй яав гэж. Тэгээд үүнийг мэдсээр байж, тэрчлэн анхнаасаа өөрсдөө санаачилж эхлүүлчихээд эцэст нь ингэж өөрсдөө “новшрох”

байдал нь МАН-ыг, МАН-ын бүлгийг маш муухай дүр төрхтэй харагдуулж байна. Амласан бол биелүүлж, эхлүүлсэн бол дуусгах нь улс төр хийж байгаа хүмүүст хамгийн чухал чанар агаад карьерт нь нэмэх оноо авчирдаг хүчин зүйл.

Хэдийгээр сэвтсэн нэр хүндээ цэврээр сэргээх боломжгүй ч, байгуулж болох ганц гавьяа уг нь энэ парламентад үлдсэн. Хамгийн гол нь МАН-ын 65 гишүүн яагаад ч юм байгуулж болох гавьяагаа үгүйсгээд байгааг нь нийтийн эрх ашгаас амин хувийн ашиг сонирхлоо нэгд эрэмбэлснээс болж байна гэж дүгнэж болно. Түүнээс биш АН-ын байр суурь тэдэнд огт падгүй, ямар ч нөлөөгүй шүү дээ. Гагцхүү Ерөнхийлөгч Х.Баттулгын

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ
Цэргийн ууган ангийн нэг, “Холбооны тусгай хороо” хэмээн алдаршсан Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн 90 жилийн ойг тохиолдуулан Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж тус ангийг Цэргийн гарвьяаны улаан тугийн одонгоор шагнажээ. Одон гардуулах ёслолд ЕТГ-ын дарга З.Энхболд оролцон зарлиг сонордуулж, Монгол Улсын зэвсэгт хүчний удирдлагын холбоог найдвартай хангах үйлсэд амжилт гаргасаар хүрсэн бие бүрэлдэхүүнд баяр хүргэжээ.

» ПАРЛАМЕНТ
УИХ-ын дарга Г.Занданшатар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын талаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийж, сарын дараа нээлттэй сонсгол зохион байгуулах үүрэг чиглэл өгсний зэрэгцээ улс төрөөс хараат бус ажлын хэсэг байгуулахаар болсныг мэдэгдэв.

» НАМУУД
УИХ дахь МАН-ын бүлэг хуралдаж, 2020 оны улсын нэгдсэн төсвийн хэлэлцэн УИХ-ын даргын захирамжаар төсвийн төслийг парламентын дөрвөн хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсэг байгуулах санал гаргав. Тус ажлын хэсэгт эрх баригч намын болон сөрөг хүчний төлөөллийг оролцуулахаар төлөвлөжээ.

» ЗАСГИЙН ГАЗАР
Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНКаЗ-д хийсэн албан ёсны айлчлалынхаа төгсгөлд Нур-Султан дахь “Астана Опера” Улсын дуурь бүжгийн театр, Үндэсний музейн үйл ажиллагаатай танилцжээ. Мөн театр, музейн бүтээн байгуулалтыг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй уулзан, туршлага солилцох, хамтран ажиллах талаар ярилцсан байна.

1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.

Д.Эрдэнэбат: Дахин хориг тавиулахгүйн тулд Ерөнхийлөгчтэй хийх зөвшилцөл чухал

АН-ын гурван саналыг МАН-ын бүлэг хүлээж авчихвал зөвшилцөл үргэлжилнэ

П.Батбөх
ЗГМ

Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэрхэх талаар УИХ дахь МАН-ын бүлэг, АН-ын зөвлөл, Ерөнхийлөгчийн зүгээс хамтран байгуулсан зөвшилцлийн ажлын хэсэг гурвантаа хуралдсан ч ойлголцолд хүрч чадалгүй гацаанд ороод байгаа. Тус ажлын хэсэгт АН-ын зөвлөлийг төлөөлөн ажиллаж буй Д.Эрдэнэбатаас зөвшилцөл яагаад гацсаныг тодрууллаа.

–Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хуулийн зөрчлөөс гаргахын тулд холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулсан гэлээ. Одоо хэлэлцүүлэг үргэлжлэх боломж бүрдсэн үү?

–Ерөнхийлөгчийн зүгээс

хуулийн зөрчлөө арилга гэж хориг тавьсан. Зөвшилцлийн ажлын хэсэг юуны түрүүнд Үндсэн хуулийг хэлэлцэхдээ дагаж мөрдөх журмын тухай хуулиа зөрчсөн гэдэг дээр байр суурь дээр нэгдэж, түүнийг залруулах ажлыг өнгөрсөн долоо хоногт хийсэн. Үүнээс гадна УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан. Үүгээрээ зөвшилцлийн ажлын хэсэг эхний алхмаа амжилттай хийчихлээ. Намын эрх ашиг ярьж байснаа бодвол зөвшилцлийн ажлын хэсэг ойлголцсон. Зөвшилцөл зөөлрөх шинждээ орсон. Одоо манай намаас тавьсан гурван саналыг МАН-ын бүлэг хүлээж авах уу гэдэгт л очоод тулчихаад байна.

-Танай намын саналыг хүлээж авахгүй байх ямар шалтгаан байна вэ?

–АН Үндсэн хуулийн өөрчлөлтөд чухал нөлөөтэй, өнгөрсөн 29 жилийн алдаа дутагдлыг засахуйц гурван санал тавьсан. Нэгдүгээрт, УИХ-ыг сонгуулийн холимог тогтолцоог сонгосноор парламент бодлогын хувьд зөв ажиллах суурийг тавих юм. Үүнийг намын нэрээр баахан улсууд парламентын гишүүн болох гэлээ гэж буруу ойлгоод байх юм. Жагсаалтаар

орох нэрснийг ямар ч байдлаар өөрчлөх боломжтой. УИХ-д бодлого тодорхойлох, мэргэжил бүрийг хамарсан, туршлагатай улстөрчдөө оруулаа-гүйгээс алдаж байгаа зүйл энэ парламентын хугацаанд харагд-лаа. Тиймээс тэр хүмүүсийг оруулах боломжийг нээж өгөх хэрэгтэй.

Зөвшилцөл зөөлрөх шинждээ орсон

Хоёрдугаарт, парламентын тогтолцоотой улс юм бол Ерөнхийлөгчөө парламентаасаа сонгодог дэлхийн жишигт нийцэх ёстой. Тэгээгүйгээс болж олон толгойтой засаглалын хэлбэр улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэж, улсын хөгжилд саад болсоор байгаа. Үүнийг засаж, сонгодог парламентын жишиг рүү явъя гэж байгаа юм. Гурав дахь нь хууль хэрэг-жүүлэх гол субъект болох Ерөн-хий сайддаа эрх мэдлийг нь өгөөд хариуцлагын тогтолцоог сайжруулна. Ингэснээр парла-

мент “шүд сугалдаг”, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын ажилд оролцдог байдал арилна. Парламент хууль тогтоох эрх мэдлээ л хэрэгжүүлбэ, Ерөнхий сайдад Засгийн газраа өөрөө байгуулах боломжийг бүрдүүлбэ гэж байгаа юм.

-Ерөнхийлөгчийг парламен-таас сонгох саналыг шинээр орж ирсэн гээд МАН-ынхан дэмжихгүй байгаа юм биш үү?

–Өмнөх хоёр хэлэлцүүлгийн явцад ороод дэмжигдээгүй санал. Ерөнхийлөгчийг парламентаас сонгохыг 2025, сонгуулийн тогтолцоог пропорциональ болгох заалтыг 2024 оноос хэрэгжүүлж болно шүү дээ. Манай нам өөрсдөдөө давуу байдал үүсгэж гэж санал тавьж байгаа юм шиг ойлгоод байна. Энэ бол улсын хөгжлийн төлөө санал.

-Танай саналыг хүлээж авс-наар гуравдугаар хэлэлцүүлэг өрнөх үү?

–Зарим хүмүүс Ард нийтийн санал асуулга явуулахаа больсон, гуравдугаар хэлэлцүүлэг шууд хийнэ гэж яриад байна. Өнөөдөр бид түүнийг шийдэхгүй. Зөвшилцлийн ажлын хэсэг алхам, алхмаар урагшилъя гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Эхний алхмаа хийчихсэн. Одоо хоёр дахь алхам болгож гурван институтээрээ зарчмын гурван саналаа ярилцъя, ойлголтоо нэг болгоё гэж байна. АН-ын туйлын зорилго бол энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ардчилсан Монгол Улсын эрх зүйлч бүрэн утгаар нь хангасан өөрчлөлт хийгээсэй гэсэн чин эрмэлзэл байна. Түүнээс биш улс төр хийгээд байсан зүйлгүй.

-Үндсэн хуульд нэмэлт өөрч-лөлт оруулах журмын тухай хууль, УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийг өөрчилс-нөөр Цэцэд гомдол очих “зам”-ыг хаасан гэж тооцож болох уу?

–Үгүй. Үндсэн хуулийн цэцэд

өргөдөл, мэдээлэл очих боломж нээлттэй хэвээр. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болохгүй байна гэж үзвэл дахин хориг тавих эрх нь улс эртэй. Тиймээс цаашдаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөх зайлшгүй шаардлага гарна гэж харж байгаа. Ерөнхийлөгчтэй зөвшилцөхийн тулд бид хориг тавихгүй байх, хуулийн зөрчилгүй болгох тал дээр анхаарч ажиллах болж байна. Ер нь улс орны эрх ашгийн төлөө бид нэгдмэл ойлголтод хүрэх нь чухал.

-Та нарын зөвшилцөж ойл-голцсон саналуудыг парла-ментын гадна байгаа улс төрийн хүчнүүд зөвшөөрөхгүй гээд Цэцэд хандвал яах вэ?

–Харин ч парламентын гадна байгаа намуудын эрх ашиг, олон нийтийн хүсэлд нийцсэн сана-луудыг суулгаж гэж байна. Тийм ч учраас тэдний зүгээс дуугүй байна гэж ойлгож байгаа. [ЗГМ]



Эрх баригч намын 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс...

Нийтлэлчийн булан

Итгэлийн зээлийн оронд ипотекийг санхүүжүүлбэл 5000 айл байртай болно

Ирэх оны төсөвт ипотекийн зээлийн санхүүжилтийг хоёр дахин багасгахаар тусгажээ

Г.Байгал
@baigalZGM

Ходоод нь хоосон, хоногийн хоолоо арай ядан аргацааж буй иргэдэд мөнгө үнэртүүлдээд, молиго үмхүүлдэг арга Монголын улс төрийн моодноос гарахгүй нь. Хүүхдийн 20 мянган төгрөгөөр эхэлсэн сонгуулийн амлалт 20 сая болтлоо суга өсжээ. Эрх баригчид ээлжит сонгуулийн сурталчилгаагаа “Итгэлийн зээл”-ээр эхлүүлсэн нь өнгөрсөн хаврын турш иргэдийн инээд, эгдүүг зэрэг хүргэсэн. Гэтэл арай ч ийм явуургүй арга ашиглахгүй байлгүй дээ хэмээн найдаж байсан иргэдийн итгэл хөсөр хаягдаж, нэр бүхий гишүүд “Итгэлийн зээл”-ийг хуулийн төсөл болгон энэ сарын эхээр УИХ-д өргөн барилаа.

Өнгөрсөн хавраас хойш “Итгэлийг зээл”-ийг итгэлтэй нь аргагүй зүтгүүлж буй хуулийн төсөл санаачлагчид иргэдийн гуравны нэг нь ядуу байгааг шогширон гайхаад, ядуурлаас иргэдээ ангижруулахаар эргэлт буцалтгүй шийдсэнээ бахархалтай нь аргагүй хэлж байна. Тэд бага орлоготой иргэдийг тэтгэж, жижиг, дунд бизнесийг дэмжих чихэнд чимэгтэй, ажил хэрэгч тайлбараар халхлан иргэдийн саналыг худалдан авч, сонгогчдыг хахуульдахаар зорьж буй нь энэ. Бага хүүтэй, барьцаагүй энэ зээлд нийт 200-300 тэрбум төгрөг зарцуулахаар хуулийн төсөлд тусгажээ. Бас болоогүй энэ мөнгө нь дөнгөж эхлэл бөгөөд ирэх жилүүдэд илүү нэмэгдэнэ хэмээн иргэдээ “боддог” УИХ-ын гишүүд амлаж байгаа юм.


Улстөрчид ийнхүү барьцаагүй, батлан даагчгүй, эргэн төлөгдох нь тодорхойгүй зээлд баруун солгойгүй мөнгө цацахаа амлаж байгаа атлаа Улаанбаатарын агаар, орчны бохирдолд цэг тавих ипотекийн зээлд “илүүчлэх мөнгөгүй” хэмээн мөрөө хавчиж сууна. “Итгэлийн зээл” бол төсвийн мөнгөөр тоглон, сонгогчдыг татах гэсэн, хөнгөн хуумгай, тооцоо судалгаагүй башир арга. Харин ипотекийн зээл бол тохь тухтай орчинд амьдрахаар шударгаар хөдөлмөрлөж буй Монголын мянга мянган иргэний хүсэн хүлээж буй санхүүжилт.

Хананаасаа халуун ус авдаг, халаалт дулаантай орон сууцны эрэлт өндөр байгаа нь шил шилээ дарсан тооцоо судалгаанаас харагддаг. Хоёр хүрэхгүй сарын өмнө Нийслэлийн орон сууцны корпорациас зарласан түрээсийн орон сууцны сугалаанд нийлүүлэлтээс даруй 35 дахин их хүсэлт ирсэн нь байртай болох гэсэн иргэд, нийслэлчүүдийн хүсэл ямар буйг түвэггүй хэлээд өгнө. Бүр зайлшгүй шийдэх ёстой тулгамдсан асуудал болсныг эндээс харж болно.

Гэвч Монголын мянга мянган айл өрхийн энэ хүсэл сүүлийн гурван жил төрийн бодлогоор илт хавчигдан хясагдаж, найман хувийн хүүтэй орон сууцны хөтөлбөрийг чиглэх санхүүжилт улам танагдсаар. Төсвөөс ипотекийг чиглэх санхүүжилт ирэх онд бараг хоёр дахин буурсан нь байртай болох хүсэлтэй олон мянган иргэнийг цөхрөөн туйлдуулж байна. Энэ онд 115 тэрбум төгрөгтэй тэнцэж буй төсвийн санхүүжилтийг ирэх онд 60 тэрбум төгрөг болгохоор 2020 оны төсвийн төсөлд тусгажээ. Утаанбаатарын утааг бууруулж, иргэдийг орон сууцжуулах чухал зорилтыг “Итгэлийн зээл” мэтийн улстөрчдийн явуургүй аргууд дөнгөлж, гацааж байгаа нь энэ.



Ж.Гэрэлчулуун / ЗГМ©



Ипотекийн зээл бол Улаанбаатарыг утаанаас бүрмөсөн ангижруулах орон сууцжуулах бодлогын гол хөшүүрэг. Их бүтээн байгуулалтын үе буюу 1921-1990 онд Улаанбаатар хотын 100 мянган айл өрхийг халаалт, халуун устай орон сууцанд оруулсан нь Монголын түүхэнд тодоор бичигдэх үйл явдал болсон.

Гэтэл бараг 70 жил хийсэн их бүтээн байгуулалттай тэнцэх хэмжээний үр дүнг Ипотекийн зээлийн хөтөлбөр тавхан жилийн дотор авчирсан. 2013 оноос эхлүүлсэн орон сууцны найман хувийн хүүтэй зээлийн хүрээнд орон байртай болсон иргэдийн тоо 2019 оны гуравдугаар сарын байдлаар 95 мянгад хүрч, утаа гаргадаг төдий тооны янданг буулгалаа. Монгол хүнийг үл

хөдлөх хөрөнгөтэй болгож, олон нийтийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, дундаж давхаргын хөрсийг бүрдүүлсэн гээд ипотекийн зээлийн ил, далд ач холбогдлыг дурдаад байвал дуусахгүй.

Зөвхөн Улаанбаатараар хэдхэн жилд Монголын томоохон хотуудын хоолойг хэдийн боомилж эхэлсэн агаар, орчны бохирдлыг ор үндэсгүй зогсоох дэлхийн нийтийн шалгарсан арга бол иргэдээ орон сууцжуулах л шүү дээ. Эдүгээ монгол хүнийг эрдэнэт амийг авч одсон хэрэгт “сэжиглэгдэж” буй сайжруулсан тулш, утаагүй зуух зэрэг нь үнэндээ түр зуурын, арга ядсан алхам. Албаныхны аминдаа хир халдаахгүй байгаа сайжруулсан түлшийг шинэ цагийн монголчууд

хэдий болтол түлж, утаа тортогтой зууралдаж, усаа худгаас зөөх вэ.

Энэ бүхнийг нэг дор, бүр мөсөн шийдэх эцсийн сонголт нь хүссэн хүсээгүй ипотекийн хөтөлбөр. Гэтэл ийм үлэмж ач холбогдолтой, монголчуудын хүсэн хүлээж буй төслийг нүд үзүүлрэх атлаа барьцаагүйгээр ажилгүй, орлогогүй иргэнд хямд мөнгө өгөхөөр улстөрчид улайрч байна. Ингэснээр төр өөрөө иргэдийг бэлэнчлэх сэтгэлгээ, залхуу хойрго зан руу түлхэж, ядуурал, ажилгүйдлийг өөгшүүлж буйгаас өөрсгүй биш гэж үү.

Эргэн төлөгдөх баталгаагүй “Итгэлийн зээл” эцэстээ шударга татвар төлөгчдийн олон тэрбум төгрөгийг сонгуулийн салхинд хийсгээд дуусна. Гэтэл эрх баригчдын нүд үзүүлрэг буй

ипотек эдүгээ Монголын банк санхүүгийн системийн хамгийн найдвартай зээлийн эхэнд эрэмбэлэгддэг. Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хувь 98 хувьтай байгаа нь Монголын санхүүгийн салбарт төдийгүй олон улсыг алмайруулдаг үзүүлэлт.


Жилийн гурван хувийн хүүтэй, жижиг, дунд бизнест зориулсан санхүүжилтээ тэрбум, тэрбумаар нь цусалсан улстөрчид гэнэт ухаан орсон мэт “Итгэлийн зээл”-ээр иргэдийг хошигируулахыг хүсжээ. Санаа нь тодорхой л доо. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хулгайлсан хулгайгаа зөвтгөн, ижил хүүтэй зээлийг иргэдэд санал болголоо гэсэн санаа мөн үү! Энэ бол зүгээр сонгууль дөхсөнтэй холбоотой улстөрчдийн ээлжит утопи популизм.

2019 оны эхний есөн сарын

байдлаар 313 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 4447 иргэнд олгосон гэж байна. Энэ дүнгээс үзэхэд эрх баригчдын сонгууль угтан гараа угаах гэж буй “Итгэлийн зээл”-ийн 300 тэрбум төгрөгөөр ипотекийн зээлийг санхүүжүүлбэл Монголын 5000 айл өрх орон байртай болж, Улаанбаатарын 5000 янданг буулгах боломжтой гэсэн үг. Гэтэл ийм нүдэнд харагдаж, гарт баригдахуйц үр дүн авчирч, барилгын салбар, дотоодын үйлдвэрлэлд түлхэц үзүүлдэг бодит хөтөлбөрөөс мөнгө танаж буй нь иргэдээ, эх орноо бодсон шийдвэр мөн үү.

Цаашлаад ажилгүй, орлогогүй, аливаа юмыг амар хялбараар авчих сонирхолтой иргэдийг дэмжих “Итгэлийн зээл” эрх баригчдын хэлээд байгаа шиг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих юм уу. Сайндаа л цөөн хэд нь урд зүгийн бараанд явж, дийлэнх нь зугаа цэнгэл, архи дарс болоод дуусна гэж мөрийцөхөд ч бэлэн байна.

Иргэдээ орон сууцаар хангасан, хүн амьдрах хамгийн таатай орчин бүрдүүлсэн Сингапур улс ипотекийн хөтөлбөрийг төрийн бодлогоороо өргөжүүлж байхад хүн амын талаас илүү нь эсгий гэрт амьдарч буй Монгол Улс ипотекийн бодлогоос ухарч болох уу. Монголын ард түмэн номхон байж болох ч тэнэг биш. Чихэн дээр цэцэг ургуулж, шилний цаанаас чихэр долоолгосон шийдвэрүүдээ хэдийн хаширсан гэдгийг ойлгуулаад өгөх байлгүй дээ. [ЗГМ]



С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм

Хөгжлийн бэрхшээлтэй 73.2 мянган иргэний 0.04 хувь нь л ажлын байртай болжээ

Байгууллагууд 25 хүн тутамд нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах ёстой

Т.Намуунболор
ЗГМ

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй 103 мянга гаруй иргэн бий. Гэвч хөдөлмөрийн насны 73.2 мянган иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Нийгэмд багагүй жин дарах тэдгээр иргэдийн хувьд ажилд орсон ч ялгаварлан гадуурхагддаг байдлаас болж орлогогүй, ядуу гэсэн давхаргыг зузаалсаар байгааг анхааралгүй орхиж болохгүй.

Уг нь хуулиараа аж ахуйн нэгж, байгууллагууд 25 хүн тутамд нэг хөгжлийн бэрхшээлтэй эсвэл одой хүн ажиллуулах ёстой. Хэрэв энэ заалтыг биелүүлээгүй тохиолдолд байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн хэмжээний төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн санд тушаах ёстой юм. Гэхдээ энэ бол зөвхөн хотод үйлчлэх хэмжээ бөгөөд орон нутагт тухайн байгууллагын дундаж цалингийн 60 хувь байхаар шинэчлэн баталжээ. Энэ онд Хөдөлмөр эрхлэлтийн санд уг төлбөрөөс орж ирсэн 1.8 тэрбум төгрөг цугласан байна. Энэ мөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулдаг аж.

“Санд төвлөрсөн дээрх хөрөнгийг хуваарилалтын дагуу зургаан хөтөлбөрт зарцуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөлбөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хэчнээн төгрөг төсөвлөснийг нарийн хэлэх боломжгүй. Бүх зүйл хуулийн дагуу явагдаж байгаа.



ЗГМ©

Одоогоор амралттай байгаа учир дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Мөн 111-р зүйлтэй холбоотой хуулийн заалт өөрчлөгдөж, торгуулийн хэмжээ орон нутагт хамгийн бага цалингийн дүнгээр, хотын бүс нутгуудад дундаж цалингаар тооцогдох болсон” гэх тайлбарыг холбогдох албанаас өгсөн юм. Гэвч бодит байдал дээр хуулийн хэрэгжилт болоод хөтөлбөрийн үр дүн хангалтгүй байна.

Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгуулж,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд зуучилж байгаа юм. Одоогоор тус байгууллагаар дамжуулан 100 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах хүсэлтээ ирүүлжээ. Хэдийгээр ажиллах хүч болон ажлын байрны эрэлт байгаа боловч дээд боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрны олдоц тааруу байгааг албаны хүн хэлж байв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хэрхэн

явагдаж байгаа талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Лхагвасүрэнгээс тодруулахад “Энэ оны есдүгээр сарын байдлаар тус хөтөлбөрийн хүрээнд 103 иргэнийг ажилд зуучилж, тэдний 35 нь ажлын байраар хангагдсан. Энэ үйл ажиллагаанд дөрвөн сая төгрөг зарцуулсан. Мөн 1283 иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулсан” гэсэн юм.

Манай улс 12 сараас дээш хугацаагаар хөгжлийн бэрх-

шээлтэй иргэнийг тогтвортой ажиллуулсан аж ахуй нэгжид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулал олгодог. Өнгөрсөн онд 34 аж ахуй нэгжид 98.9 сая төгрөг, энэ онд 19 аж ахуй нэгжид 48.9 сая төгрөгийн урамшууллыг үүний хүрээнд олгосон байна.

● **Өнгөрсөн онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулсан 34 аж ахуй нэгжид 98.9 сая төгрөг, энэ онд 19 аж ахуй нэгжид 48.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.**

● **Хөгжлийн бэрхшээлтэй 1283 иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулжээ.**

● **Дээд боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрны олдоц тааруу байна.**

Гэхдээ 73.2 мянган хүнээс ердөө 35 нь буюу 0,04 хувь нь ажлын байртай болж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Хууль эрх зүйн орчноор хангаж, бие даасан агентлаг байгуулж, хэдэн арван саяын урамшуулал, торгуулийн системийг бий болгосон атал хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилд орох боломжоор хангагдаж чадахгүй хэвээр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд анхаарна гэхээр зөвхөн ажилд зуучлах, сургалтад хамруулах төдийгөөр хязгаарлагдахгүй. Ажилд авсан ч ажиллах нөхцөл, ахиж дэвших боломжоор

хангахгүй, зөвхөн нэр төдий байлгадаг компани ч бий.

Энэ талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөөс тодруулга авсан юм. Нэрээ хэлэхийг хүсээгүй тэрбээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг бөгөөд үйлчилгээний байгууллагад борлуулалт хариуцсан мэргэжилтнээр ажилд орсон ч гурван сарын дараа өөрийн хүсэлтээр халагдсан байна.

-Та ямар шалтгааны улмаас ажлаасаа гарсан юм бэ?

-Би хөдөлгөөний бэрхшээлтэй хүн. Ажлын цаг уртаас гадна цалин хангамжийн асуудал надад тулгарсан. Гэхдээ үүнээс илүүтэйгээр ажилдаа ирж очиход маш их хүндрэлтэй. Автобусны жолооч нар бидэнд суух боломж хэзээ ч олгодоггүй. Бараг л зугтаах шахам явдаг. Ингээд таксинд суухаас өөр аргагүй болно. Түүнээс гадна байгууллагын зүгээс надад бусад ажилтантай адил шаардлага тавьдаг ч ажиллах, өсөж дэвших тэгш боломжоор хангаж байгаагүй.

-Байгууллагын зүгээс таны ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар ямар нэг алхам хийсэн үү. Ямар байдлаар тэгш зөв хандлага гаргасан юм бэ?

-Миний тусгай хэрэгцээг хангах ямар нэг зүйл хийгээгүй. Анх намайг ажилд авахдаа “Та нарын хэн нь ч байсан ажлаа хийж чадаж байвал өсөж дэвших боломжтой” гэж хэлсэн. Гэтэл надтай хамт ажилд орсон ажилтнуудыг бусад салбар руу, эсвэл олон нийтийн арга хэмжээ рүү явуулдаг атлаа намайг үлдээдэг байсан. Би өөрийгөө энгийн л хүн гэж боддог. Надад бусад ажилтантай адилхан шаардлага тавьдаг хэрнээ ажлын байрны чиг үүргийн дагуу ажиллах бололцоог маань хаадаг байсан. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn

ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

865800042911201230

мэдээ, мэдээлэл Нийслэлд түүхий нүүрс оруулахыг завджээ

Улаанбаатар хот руу түүхий нүүрс оруулахыг хориглосон Засгийн газрын шийдвэр өнгөрсөн тавдугаар сарын 15-уаас хэрэгжиж буй. Хүйтний улирал ирсэнтэй холбогдуулан иргэд хот руу түүхий нүүрс оруулахыг завдсан тохиолдол цөөнгүй гарч байгааг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас мэдээлэв. Тухайлбал, энэ сарын 12-нд суудлын автомашинд 10 шуудай нүүрс тээвэрлэж явсныг нийслэлийн Мэргэжлийн хяналтын байцаагчид илрүүлсэн байна. Мөн сарын 13-ны өдөр 13 шуудай нүүрсийг Улаанбаатарт оруулж ирэх гэж байдлыг илрүүлж, нүүрсийг буцаажээ. Энэ мэтчилэн түүхий нүүрс нийслэл рүү нэвтрүүлэх оролдлого нэмэгдэж байгааг албаныхан анхааруулж байна.

Нийслэл рүү түүхий нүүрс оруулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар иргэнийг 300 мянга, аж ахуйн нэгж болон байгууллагыг гурван сая төгрөгөөр торгох юм. [ЗГМ]

“Монгол тэмүүлэл”-ийг нүүлгэтэл хүүхдүүдээ хичээлд нь явуулахгүй гэв



Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

Г.Санжааханд
ЗГМ

Дөрвөн ээлжээр хичээллэж буй 133 дугаар сургуулийн эцэг эхчүүд өчигдөр Сүхбаатарын талбай эсэргүүцлээ илэрхийлэн, жагсаал зохион байгуулав. Учир нь тус сургуулийн байранд “Монгол тэмүүлэл” лаборатори сургууль мөн үйл ажиллагаа явуулдгаас ачаалал нь ихсэж, суралцагчид дөрвөн ээлжээр хичээллэх болсон байна.

1600 гаруй сурагчтай 133

дугаар сургууль БЗД-ийн 26 дугаар хороонд байдаг ганц төрийн өмчийн сургууль. Тус хороонд сургуулийн насны 5400 хүүхэд байдаг боловч үүний ердөө 1600 нь 133-т явдаг.

“Манай хороонд байгаа улсын 133 дугаар сургууль нь өөрийн гэсэн байргүй бөгөөд БСШУС-ны харьяа “Монгол тэмүүлэл” сургуулийн дөрвөн давхар барилгын нэг болон хоёрдугаар давхарт 1600 хүүхэд арай ядан багтаж, дөрвөн ээлжээр хичээллэж байна. Уг нь энэ барилгын газрыг “Женерал Тек”

ХХК нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, манай хорооны хүүхдүүд сурах сургуульд үнэ төлбөргүй шилжүүлсэн. Улмаар 2014-2015 оны улсын төсвөөс 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, тус сургуулийг барьсан боловч харамсалтай нь БСШУС-ын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатар 2017 оны есдүгээр сарын 20-ны өдөр тушаал гаргаж, хууль бусаар “Монгол тэмүүлэл” сургуульд эзэмшүүлсэн байсан” хэмээн эцэг эхийн зөвлөлийн дарга Б.Батдэлгэр ярив.

Нийслэлийн 133 дугаар сургуулийн эцэг, эхчүүд өнгөрсөн хавраас эхлэн “Монгол тэмүүлэл” сургуулийг өөр тийш нь нүүлгэхийг хүссэн байна. БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг хүсэлтийг хүлээн авч, өнгөрсөн наймдугаар сарын 30-нд тус сургуулийг нүүлгэх байрыг бэлтгэх хоёр Ажлын хэсэг гаргасан боловч уг тушаал гарснаас хойш 45 хоногийн хугацаа өнгөрөхөд ямар ч ахиц дэвшил гараагүй байна. Тиймээс эцэг эхчүүд хүүхдүүдээ хичээлд нь явуулахгүйгээр эсэргүүцлээ илэрхийлнэ хэмээн мэдэгдэв. [ЗГМ]

СХД-ийн гэр хорооллын 53 мянган өрхөд түлшний талаар зөвлөмж тараалаа

Засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн

бэлэн байдал зарласан.

Энэ хүрээнд Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн сайжруулсан шахмал түлшний зөв хэрэглээг хэвшүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийслэл, дүүргээс

явуулж буй арга хэмжээг иргэдэд сурталчлах ажлыг хэрэгжүүлсэн. Сонгинохайрхан дүүрэгт гал галлаж буй 57 мянган айл өрх байдаг. Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага,

Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, хороодын албан хаагчид нийлсэн 1300 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж, 53 мянган өрхөд сайжруулсан түлшний зөв хэрэглээний зөвлөмж мэдээг хүргэжээ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ДЭД БҮТЭЦ

Замын цагдаагийн ойролцоох гүүрэн гарцын буцах эргэлтийн зорчих хэсгийн хөдөлгөөнийг өчигдөр нээлээ.

» ОРОН НУТАГ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Өтгөн багийн Хайлаастын энгэр гэдэг газар 4.3 магнитудын хүчтэй газар хөдлөлт болжээ.

» ҮЙЛЧИЛГЭЭ

“УБТЗ” ХХН-ээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай үйлчилгээний галт тэргийг даваа гараг бүр Эрдэнэтийн чиглэлд тогтмол аялуулж эхэллээ. Мөн долоо хоног бүрийн лхагва, бямба гарагт Дархан, пүрэв гарагт Замын-Үүдийн чиглэлд аялуулж байгаа аж.

» ЭРҮҮЛ МЭНД

Халдварт өвчнөөр өвчлөгчид энэ оны эхний өсөн сард 32.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1168-аар нэмэгджээ. Үүнд салхин цэцэг, тэмбүү, мөөгөнцөр, сүрьеэ, гонококкт халдвараар өвчлөх тохиолдол өссөн нь голлон нөлөөлсөн байна.

» ТЭЭВЭРЛЭЛТ

Хан-уул дүүрэг Нисэхийн тойргоос Биокомбинат, Шувуун фабрик хүртэлх замд хайрга ачсан том тэрэгний ачааг стандартад заасны дагуу хязгаарлаж, хут руу орох тээвэрлэлтийн хугацааг 08.00-22.00 цагт хааж байхаар төлөвлөжээ.

Цаг үе


Улаанбаатарчууд уушгины хавдраар “дуусах” цаг ойрхон болжээ

◄1 Тэрбээр BloombergTV Mongolia-д өгсөн ярилцлагадаа “Агаарын чанарын тунгалагшил гэж нүдээр хараад хэлж болдоггүй бохирдол бий. Шахмал түлш шатаах үед хүхэртэй нэгдлүүд, азотын ислүүд гэх мэт шууд үхэлд хүргэхгүй ч хүний биед хортой олон тооны нэгдэл ялгардаг. Энэ түлш хоёр дахин илчлэгтэй учраас шатахдаа хоёр дахин их хүчиртөрөгч ашиглаж, ялгаруулж байгаа хорт хийн хэмжээ мөн хоёр дахин их болно гэсэн үг” хэмээн тайлбарласан.

Монгол орны аль ч уурхайгаас олборлосон нүүрсэнд хүхрийн агууламж тодорхой хэмжээгээр байдаг. Хүхэрлэг хий нь хүний уургийн солилцоо, дааврын үйл ажиллагааг алдагдуулдаг хорт нэгдэл. Мөн амьсгалын дээд замыг цочроох нөлөөтэй. Хүхрийн давхар ислийн 90 хувь нь амьсгалын дээд замд шингэж, гуурсан хоолойн үрэвсэлт өвчин үүсэхэд хүргэдэг байна. Мөн хүхрийн ислүүд нь салстын цэвэрлэх үүргийг дарангуйлдаг. Хүхрийн давхар исэл нь жигнэгдэгч бодис буюу РМ 2.5-10-тай хавсарсан бол илүү хүчтэй нөлөө үзүүлдэг. Тухайлбал, ийм хүхрийн давхар исэл нь уушгины эдийг түлэх аюултай.

Хүхэрлэг хий амьд биетийн эрүүл мэндэд ямар нөлөөтэйг судлахаар эрдэмтэд хулгана дээр туршилт хийж байв. Нэг шоо метр агаарт 56 мкг хүхэрлэг

Азотын давхар исэл, хүхрийн нэгдэл утааны хорыг нэмэгдүүлж эхэллээ



хийн агууламжтай нөхцөлд эр, эм хулганыг өдөрт зургаан цагаар,

долоон өдрийн турш байлгажээ. Ингэхдээ тархи, уушги, зүрх,



Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

элэг, ходоод, нарийн бүдүүн гэдэс, цөс, бөөр болон төмсөг гэсэн есөн төрлийн эрхтэний үйл ажиллагаанд ажиглалт хийсэн байна. Судалгааны дүнд хүхэрлэг хий нь зөвхөн амьсгалын замын төдийгүй бусад олон эрхтэнд нөлөөлдөг, амьтны эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг хүчтэй гэмтээх нөлөөтэй, олон төрлийн өвчлөлийн явцыг түргэтгэх нөлөөтэй гэж тогтоожээ.

Харин азотын давхар исэл нь хүний хамар, нүдний салст бүрхэвчийг цочроож улмаар уушгины цуцланд шингэн хуримтлуулах нөлөөтэй. 1992 онд Германы судлаачид азотын давхар ислийн 564 мкг/м3 тунгийн нөлөөлөлд 19-35 насны дунд зэргийн багтраа өвчтэй хүмүүсийг байлгахад эхний 10

минутанд л уушгинаас огцом гаргалтын агаарын эзлэхүүн 11 хувиар буурч байжээ. Энэ нь уушгинд нөлөөлж буй азотын давхар ислийн хорт нөлөөг тодорхой харуулсан судалгаа гэж үздэг аж.

Агаарын чанар хэмжигч багажууд автомашины бохирдол ихтэй газруудад азотын давхар исэл өндөр заадаг байлаа. Учир нь энэ нэгдэл аливаа түлш өндөр температурт шатах үед үүсдэг ба авто тээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг агаар бохирдуулах эх үүсвэрээс ялгардаг. Харин одоо зөвхөн түгжрэл ихтэй газруудад бус, агаарын чанарын агууламжид тэр чигт нь нөлөөлж байгаа нь

харагдаж байна.

Эдгээр бодис нь амьсгалын замын халдварт биш болон хурц халдварт өвчнүүд, гуурсан хоолойн багтраа, зүрх судасны өвчин, уушгины хавдар үүсэх урьдач нөхцөл болдог. Улмаар хүн амын нас баралтын түвшинд нөлөөлөх хүчин зүйл болдгийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын судлаачдын бүтээлээс харж болно. Дээрх өвчин үүсэхэд тухайн хүний нас, эрүүл мэндийн байдал, архи, тамхины хэрэглээ, ахуйн болон ажлын байрны нөхцөл зэрэг үзүүлэлтүүд нөлөөлөх нь тодорхой ч Улаанбаатарын хувьд 200 мянган яндангаас ялгарах утаан дахь хоёр дахин нэмэгдсэн хорт бодисын хөнөөлөөс хэн ч зайлж чадахгүй. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Б.Жаргалсайхан: Зуух бол машин гэдгийг ойлгохгүй байна



“Монголчилсон” нийшинд илчлэг ихтэй шахмал түлш тохиромжгүй

Д.Хулан
ЗГМ

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн аливаа түлш, төрөл бүрийн зуух, утаа мэдэрэгч гээд дулааны холбогдолтой бүхий л бүтээгдэхүүн, технологийг судалж, зөвшөөрөгдсөн хэмжээ, стандартыг гаргаж өгдөг. Уг хүрээлэнгийн захирал Б.Жаргалсайханаас өнөөдрийн шахмал түлш тойрсон эргэлзэлтэй шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар авахыг зорьсон юм. Дулааны хүрээлэнгийн лаборатори нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны санхүүжилтээр босгосон, Монголд төдийгүй Азидаа ганц дулааны шинжилгээний төв гэж тооцогддог.

-Танай байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?

-Аймаг сумдын шаталтын технологиг оновчтой болгох, горим тогтоох, сайжруулах, шинэ технологи нутагшуулах гэх мэт зуухтай холбоотой ажил хийдэг. Мөн зуухнаас гарч байгаа бохирдлыг хянаж тогтоох, бууруулах талын арга хэмжээ авах, тоног төхөөрөмж боловсруулах, зохион бүтээх ажлуудыг хариуцдаг.

-Налайх, Багануур, Алаг толгой, Тавантолгойн нүүрсний ямар зууханд, яаж шатаах гори-

мыг танайхаас гаргана гэсэн үг үү?

-Манай хүрээлэнгийн үндсэн ажил бол аль уурхайн нүүрсийг ямар технолгиор шатаавал зохистой вэ гэдэгт судалгаа шинжилгээ хийдэг.

-Сайжруулсан шахмал түлшийг шинжилсэн үү?

-Шахмал түлшний судалгаа, хөгжлийн ажлын эхэн үед манайх оролцож явсан. Гэхдээ судалгааны явцад хий шинжилдэг анализатор багаж маань эвдэрч, оролцох боломжгүй болсон.

-Яагаад эвдэрсэн юм бэ?

-Янз бүрийн хортой хий явсаар битүүрэх, бөглөрөх, шатах асуудал байна. Өдөр бүр тасралтгүй туршилт явуулаад байхаар “мотоцаг” гэдэг шиг ашиглалтын хугацаа дүүрнэ. Уг нь жил бүр хэмжилт, баталгаажуулалт явуулж байх ёстой. Харамсалтай нь мөнгөгүйн улмаас засвар үйлчилгээг хийж чадахгүй байсаар эвдэрсэн.

-Засахад хэчнээн төгрөг хэрэгтэй вэ?

-30 гаруй мянган ам.доллар улсаас нэг ч төгрөг авдаггүй, арай гэж цалингаа тавьж байгаа газар. Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор манай хүрээлэнг төсвийн бус хөрөнгөөр ажиллуулахаар шийдвэрлэсэн юм.

-Шахмал түлшний утааны найрлагад хүмүүс хордож үхэх хэмжээний бодис байсан уу гэдэгт танайхаас тайлбар авахыг зорьсон юм. Хэдийгээр багаж эвдэрсэн ч та энэ талаар шинжлэх ухааны үндэстэй тайлбар хэлэх байх?

-Хүрэн нүүрсний шатаад, бохирдолгүй байх үеийн температур 450-460 хэмд арай нэг оптимал утгатай байна гэж бодьё л доо. Гэтэл чулуун нүүрснийх түүнээс дээш, 500-700 хэмд тогтох ёстой. Ийм дулааныг гэрийн зуух барьж чадахгүй, бөөр нь улайсаад, хаалга цонхоо нээх хэмжээнд хүрнэ. Ингэхээр эргэж хөрөөд, хүрэн нүүрсний хэмжээнд очиход дутуу шаталт үүсч, утаарын хий ихсээд байгаа юм. Тэгэхээр хамгийн ашигтай байх хэмжээнд очихгүй, дандаа бохирдолтой үед байгаад байна гэсэн үг. Сайжруулсан зуухны керамик дотор түлбэл байж болох температуртаа байгаад, бохирдол бага ялгаруулна. Иймээс сайн зууханд зөв технолгиор галлах нь чухал байна.

-Яагаад сайжруулсан зуух хорт утааг багасгана гэж?

-Нүүрс түлэхэд халалт, хаталт, дэгдэлт, шаталт гээд олон процесс явагддаг. Хэрвээ микроскопоор харвал сонин үзэгдэл өрнөнө. Зүйрлэвэл, нарны шаталтыг “Арметедон” кинонд харуулахдаа олон хэсэгт хагараад, дотроос нь хий дэгдэж, дараа нь гал дүрэлзэх мэтээр хийсэн байдаг. Яг түүн шиг процесс нүүрс түлэх явцад гардаг. Тэр хагаралт, халалтын явцад суларч байгаа нарийн ширхэгтэй РМ 2.5, РМ 10 тоосонцрууд дэгдэх үед яндан сорж аваад гадагш гаргадаг. Ингэж гаргахдаа дээр нь галласан тохиолдолд галын дөл дундуур шатаж өнгөрөөд маш бага бохирдол ялгаруулах юм. Харин доороос галласан нөхцөлд халалт, хаталтын процессын явцад үүссэн хорт бодисууд шууд яндангаар гарч, бохирдол их хэмжээгээр үүсгэдэг.

Мөн нүүрсэнд өгөх дулаан хүрэлцээгүй бол зөвхөн халалт, хаталт, дэгдэлтийн үе яваад, шаталт дутуу болдог. Өөрөөр хэлбэл, босоо керамик доторлогоотой сайжруулсан зууханд шүдэнз зурахаас эхэлсэн дулаан тэр чигтээ нүүрсээ шатаахад зориулагдана. Харин нимгэн төмрөөр хийсэн, эсвэл тоосгоор доторлосон пийшинд нүүрс шатаах температур хүрэлцдэггүй тул дутуу шаталт явагддаг. Сайжруулсан зууханд нүүрс асалт 15-30 минутын хооронд явагдаж, хорт бодис ялгаруулах үе нь өнгөрдөг бол энгийн уламжлалт зууханд нүүрс асаах процесс 20 минутаас хоёр цагийн хооронд үргэлжилдэг. Өглөө, оройны энэ үед л нийслэл утаанд автаад байна.

-Шахмал түлшийг коксжеон нүүрсээр хийсэн нь буруу гэх шүүмжлэл бас бий. Ялгаа нь юунд байдаг вэ?

-Өмнө нь бид хүрэн нүүрс түлдэг байсан. Гэтэл одоо илчлэг ихтэй чулуун нүүрс шатаахад зуухны нөхцөл таарахгүй. Нэг кг чулуун нүүрс шатаахад ойролцоогоор 4.5 кг утаа ялгардаг байа гэж бодьё. Гэрийн яндангаар утаа 3-6 м/сек хурдтайгаар дээшээ зайлуулагддаг бол ханан пийшинд 0-2 м/сек хурдтай болж саардаг. Аэродинамикийн олон саад түлгарч, утааны урсгал бараг зогсож байгаа ийм нөхцөлд ан цавтай, “монголчилсон” ханан пийшингээс угаарын хий дотоод орчинд алдагдсаар л байдаг. Өмнө нь хүмүүс бага хэмжээгээр

угаартдаг л байсан. Дархлаа сулрах, амарсан шинжгүй босч ирэх, толгой өвдөж сэрэх гэх мэтээр угаартсан шинж илэрдэг байсан.

Гэтэл одоо өндөр илчлэгтэй чулуун нүүрс хийчихээр тэр их эзлэхүүн ханан пийшингийн утаа зайлуулах хугацаанд сорогдож гарах боломжгүй болж, дотоод орчинд алдагдах эсрэдл үүсэж байгаа юм. Дээр нь нэмээд сойoltoo хааснаар үхэлд хүрэх шалтгаан болсон байна. Ингэж хэлэхээр хэн нэгнийг хамгаалах гэж байна гэж бодох байх. Гэтэл яг л ийм процесс болсон.

Монголчууд олон зуун жил гал түлсэн, хэнээр ч заалгахгүй гэдэг. Гэтэл зуух бол машин гэдгийг ойлгодоггүй. Агаарын удирдлагатай, шаталтын техноло-гитой. Харамсалтай нь үүнийг ойлгодоггүй. Манайд яг ийм байдалд гэд нэвтрүүлнэ гэвэл маш олон айл дэлбэрнэ, маш олон хүн угаартана.

-Хоёр дахин их илчтэй учраас хэрэглээ 50 хувиар буурна гэж тооцоолсон. Гэтэл энэ өндөр температурыг тэсэж үлдэх гэрийн зуух байна уу гээд байгаа юм л даа?

-Багануур, Шивээ-Овоогийн нүүрсийг цагт 10 тоннйг түлдэг станц байгаа гэж бодвол Таван-толгойн нүүрсийг таван тоннйг л түлнэ шүү дээ. Түүнээс биш 10 тонноор нь хийчихээд зуухаа буцалгаад, дэлбэлээд байж болох-гүй нь тодорхой. Үүн шиг гэртээ хэдий хэрийн энерги авмаар байна, түүндээ л тохируулж хэрэглээгээ зохицуулах хэрэгтэй.

-Шахмал түлш түлээд ширэм-лэж, дутуу шаталт үүсгээд байна гэдэг?

-Шахмал түлш олон янзын хэлбэр, хэмжээтэй байдаг. Хүрэн нүүрсээр шахмал түлш хийсэн бол дэгдэмхий ихтэй учраас халаах үед нөгөө бодисууд сугарч гараад, шаталтын орон зай үүсгээд өгнө. Харин одоогийнх шиг дэгдэмхий багатай гэх чулуун нүүрсээр хийчихээр шаталтын орон зай гаргаж өгч чадахгүй, шахсанаараа л байгаад байхаар температур хүрэлцэж, бүрэн шатааж чадахгүй нөхцөл үүснэ. Тэгэхээр түлшний хэвлэх хэмжээг багасгачихвал цөмдөө хүртэл бүрэн шатаад байх боломжтой. Нэгэнт л энэ түлшийг түлэх нь ойлгомжтой болсон тул одоо сайжруулах талын зөвлөмж өгөөд л сууж байна.

-Ямар зөвлөмж өгч байна?

-Түлшний хэмжээ том байна, барьцалдуулагч чинь арай хэтэрхий их болсон байна. Түлш унагаж үзэхэд 80 хувь нь үлдэж байвал сайн түлш. Гэтэл иргэдийн хог ихтэй байна гэдэг шүүмжлэлээс болоод улам бат бөх болгох гээд барьцалдуулагчдаа анхаараад ирсэн. Нөгөө талдаа түлш өөрөө хагарч, галын хотлоосой зайлж чөлөөлж өгөхгүй бол үлдсэн түлш нь шатах боломжгүй болгоод байна.

Манайд яг ийм байдалд газ нэвтрүүлнэ гэвэл маш олон айл дэлбэрнэ

-Барьцалдуулагчийг эрдэнэ-шиншээр хийсэн гэж үзүүлсэн. Энэ боломжтой юу?

-Яахав цардуул оролцсон байх л даа. Манайд энэ бол нэн шинэ зүйл шүү дээ. Нүүрсээ авчраад л барьцалдуулаад, 600 мянган тонныг л үйлдвэрлэхгүй бол засаг сүйрлээ гээд хоолойд нь хутга тулгачихсан. Энэ тооцоо судалгаагүй шийдвэр нь эргээд ард түмний хоолойд хутга тулгачихлаа. Харилцан очих мэхэнд орчихоод байна. Муугаасаа сайн руу явдаг болохоор хэсэг хугацааны дараа сайжрах л байх. Ямар ч байсан өнөөдөр сайжруулсан түлш рүү шилжлээ. Одоо дахиж хэзээ ч түүхий нүүрсний тухай ярилчгүйгээр зуухны асуудлыг шийдвэрлэж, шат ахиулах ёстой. Хэрэв буцаад түүхий нүүрс рүүгээ орвол дахиж хэзээ ч үүнийг ярьж, зорилгож орох хүн гарахгүй.

-Барьцалдуулагч нь ихэдсэн, шатахгүй байгаа түлшийг яах вэ?

-Уг нь монголчууд аливаа юмны арга эвийг олохдоо сайн шүү дээ. Хятад, солонгосчуудад шахмал түлшний хэрэглээний соёл суучих-сан бид гурван жилийн дараа гэхэд ийм соёл суучих байх гэж найдаад байна.

-Шинжлэх ухааны үндэстэй шаталтын процессыг сайн мэд-дэг байж танай хүрээлэнгээс утааг бууруулахын эсрэг юу хийв?

-Манай хүрээлэн нийгмийн хариуцлагаар утаатай тэмцдэг. Зөв галлагааны зуух хэд хэдийг

хийсэн. Буруу галлагааг халахын тулд зуухны дараагийн үеийг гаргаж ирэхээр зүтгэж байна. Гэтэл иргэдэд сурталчлан таниулах нь бүү хэл шийдвэр гаргагчдад үүнийгээ ойлгуулж чадахгүй байна. Ойл-гохыг хүсдэггүй юм уу, бүү мэд. Хэчнээн зөв галлагаатай зуух нэвтрүүлсэн ч цогон дээрээс нь нүүрсээ хийдэг хүн байхад ямар ч нэмэргүй.

-Танай шинэ зуух, өмнө нь тараасан төслийн зуухтай ижил гэсэн үг үү?

-Тэр зуухыг иргэд буруу гал-лаж болоод байгаа бол манай энэ зуухыг буруу галлах ямар ч боломжгүй. “Тарган хүнд зориулж хаалгаа томрууллаа” гэдэг шиг буруу галлаад байхаар одоо тэр боломжийг нь хааж үзэж байна.

-Үр дүнд хүрэхгүй байгаа шалтгаан юу вэ?

-Уг нь улс орон шинжлэх ухааны чиг баримжаатай хөгж-дөг байхад манайд дарга нарын шийдвэрийг шинжлэх ухаанд ойртуулах гэж араас нь хичээж ажилладаг. Ж.Эрдэнэбат сайдын үед цахилгааны шөнийн тарифыг тэглэсэн шүү дээ. Уг суурь нь шөнийн цагийн үнэгүй цахилгааныг хуримтлуулж аваад, өдөржингөө дулаанд зарцуулах замаар агаарын бохирдлыг бууруулах ёстой. Гэтэл манайд тийм зүйл нэг ч байхгүй байхад ийм шийдвэр гаргачихаар бид араас нь дулааны аккумулятор хийж өгөхгүй бол энэ “шаталттай” шийдвэрийг үр дүнтэй байлгах боломжгүй болсон. Ингээд пазын шилжилттэй дулааны аккумулятор зохион бүтээгээд танилцуулсан. Харамсалтай нь үйлдвэрлэх ямар ч хөрөнгөгүй гэдэг шалтгаанаар зогссон юм.

-Тэр цэнэг хуримтлуулдаг зуух одоо худалдаанд байна уу?

-Байхгүй. Нэг сая ам.долларын өртөгтэй үйлдвэр байгуулах ТЗЗҮ, зураг төсөл бүхнийг гаргаад өгсөн ч дарга нар хүссэнгүй, ирж зургаа татуулж, шинэ бүтээл гаргалаа гээд л замхарсан. Манайд ер нь шинжлэх ухааны чиг баримжаатай төсөл хөдөлж байсан тохиолдол үгүй. Иргэдэд яаж хийх аргыг нь зааж өгье, хайчилж, нугалах процессыг нь хийгээд өгье гэхээр ирж заалгах нэг ч хүн байдаггүй. Харин оронд нь хятад зуухнууд оруулж ирээд шинжилгээнд зөвшөөрсөн бичиг авахыг л хүсдэг. Бид нэг ч хятад зууханд зөвшөөрлийн бичиг олгоогүй байна. [ЗГМ]

Судлаачийн үг

Энэ их түгжрэл, түгжрэлийн бухимдал, цухалдал нэг л өдөр тэсрэлтэд хүргэнэ.



Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

ХҮНИЙ ДОР ОРОХГҮЙ



**Хослон
жаргахад хос
“Алтангадас” л
дутаж гэнэ**

Олхонуд Баярхүү
профессор

Монголчуудыг зарчимлаг залхуу ард түмэн мөн гээд Зөвлөлтийн нэрт эрдэмтэн, дипломат ч Майский тодорхойлчихсон байдаг. Энэ нь заяанаасаа залхуу, засаршгүй залхуу гэсэн утгатай юм. Үүн дээр гарчигт өгүүлсэн бас нэг чанарыг нь нэмэх гэж байна.

Энэ бол монголчуудын хамгийн зарчимлаг зарчим нь. Төрийн хууль цаазаас ч дээгүүр. Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас эрдэм өвөртлөн ирэх хүүдээ эх нь захидаг ганц захиаас. Бараг гэрээслэл ч гэж болно. “Хүний дор битгий ороорой”, “Муугаа бүү үзүүлээрэй”. Эрдэм ном, ажил төрөл, ахуй амьдрал, мөнгө цаасан дээр хүний дор орохгүй гэж яваа түг түмэн монголчуудаа баалах гэж байгаа юм биш. Арай өөр өнцгөөс хөгийн тэнэг араншинг нь илчлэн бичиж, буруушаах гэж байна. Санаа сэдэл авах тэнхээ байна уу, монголчууд минь. Гашуун ба хөгийн жишээ хөвөрч өгнө, хүмүүс ам мэдэн ярина. Ярьсаар байгаад улиг болгочихсон. Засарна гэж гонж. Бүгд болсон явдал, бүгд баримттай.

Эрх бүхий дүүргүүдийн намын байгууллагуудад “Алтангадас” одон бөөнөөрөө дарагдаастай, сонгууль болохоор гаргаж ашигладаг юм уу даа. Дүүргийн намын даргад хэд гурван цаас өгч урьдчилаад аваад зүүчихдэг, үнэмлэх дээр нь Ерөнхийлөгчийн гарын үсэг зураатай, дүүргийн намын дарга нэрийг нь бичээд л боллоо. Төрөлх сумынхаа ойн баяр наадамд уригдсан хоёр хос намын даргатайгаа ярьж байгаад хоёулаа “Алтангадас”-ыг хоёр сая төгрөгөөр аваад энгэртээ зүүчихэв ээ. Нэгийг нь нэг саяар, хоёрыг хоёр саяар. Нууц ханш нь.

Яах гэж байгаа юм гэсэн чинь сумынхаа ойн баяр наадам дээр хос “Алтангадас”-аар хоёул гоёж амьтны нүд хужирлах, улс төрд зүтгэсний хэрэг юу билээ, төрөөрөө үнэлүүлчихлээ гэж нутгийнхандаа гайхуулах, бүр арга барагдахад нийслэлд өчнөөн жил ирж суучихаад “Хүний

дор ороогүй явна шүү” гэдгээ нутагтаа очихдоо мэдрүүлэх, хүчтэйхэн эргэн очиж байгаагаа илтгэх санаа төрсөн нь энэ гэнэ. Хоёр хос маань зах дээрээс торго дурдан, хоргой аваад яг ижил дээл, хантааз хийлгэж, нэг загварын ижил өнгөтэй бүрх малгай том жижгийг худалдан авч хосолж өмсөөд жийпэндээ сэгсчүүлсээр нутгийнхаа барааг харж наадамлаж, найрлаж, хүндлүүлж гэнэ. Нутаг усныхаа нэрийг нийслэлд мандуулж яваа хоёр хосод хүндлэл үзүүлж, айраг цагаа, хорхог, мах буузаар бялууртлаа шахуулж аваад буцжээ.

Хос “Алтангадас” гэснээс төрийн одон ингэглээ доош орж үнэгүйдсэн юм бол төрийн одонгийн жагсаалтаас хасаад намуудын “Сонгуулийн одон” гээд зарлачихмаар юм. Бас нэг парадокс. Ярьж байна лээ, тэр борлуулж зардаг нөхөд нь. Том бүдүүн хар машин унахгүй бол нойр нь хүрэхээ больчихсон нөхдийн тухай болсон

явдал. Нэгэн аймгийн сумын дунд сургууль төгсөгчдийн төгсөлтийн гуч гэнэ үү, гучин тав гэнэ үү, тэмдэглэлт баярт төрсөн сумандаа очих гэсэн нэг нөхрийн тархинд “Ланд” жийп шүглэхичхэж.

**Машин барих
нь аз жаргал
уу, үйлийн лай,
зовлонгийн
далай юу**

Түүнгүйгээр очихгүй бол ёстой болдоггүй юм гэнэ. Амьтан хүний нүүр яаж харах юм, нэр төрд цөвтэй, үр хүүхдийн нэрэнд хүртэл сэвтэй, ерөөсөө л “Ланд” шинээр нь авч барьж очно гээд мань хүн хэдэн сар цамнах нь тэр. Нөгөө “Ланд” нь 245 сая төгрөг, мань хүн тэр мөнгийг

олох гэж байдгаа шавхаж, золтой л амиа өргөчихсөнгүй. Бөөн хэрүүл уруул дунд хотын төвийн хоёр өрөө байшингаа 120 саяар дөнгөн данган зарав. Ахан дүүс, амраг садангуудынхаа байр сав, зуслан, хашаа байшинг ломбардад тавиад тавиад 245 саяд нь хүргэж чадсангүй. Улаанхуаранд хоёр өрөө байрыг 80 саяар заруулах гэтэл хүн авсангүй ч гэх шиг. Дутуу мөнгөө өр болгож лизинг бололтой барьцаанд тавьж хүсэн хүлээсэн жийпнийхээ түлхүүрийг авах нь авчээ.

Буланг нь халцлах төдий л эргэж үнээ барихгүй шүү гэсэн хатуу болзолтойгоор төрөлх сум руугаа зорих гэж байгаа нөхөр гэр бүл үр хүүхдээ түрээсийн байранд оруулж орхиод аравдугаар анги төгсөгчдийнхөө баярт явав. Ердөө гуравхан хоногийн найр наадам, уулзалт, шарталт. Сумын төвийн балгас болох шахсан хэдэн халтар байшин, нурж унах шахсан хашаа хороо, дов сондуул,

шавар шалбааган дундуур 100 метр хүрэхгүй замаар нэг ганган жийптэй нөхөр л салхи татуулан давхиж, Улаанбаатарт олон жил сууж бизнес хийснээ гайхуулж яваа юм биз дээ. Жийптэй очсонд нь сумын дарга нар налж унаад л, сумын миссүүд хуйлраад л, найран дээр илүү их архи мах оногддог, сархадын дээжээр мань хүн эхлэн сэржим өргөөд л, өөр яадаг ч юм, бүү мэд. Амь амьдралаа золиослох шахан байж жийп авсны гавьяа байж л таарна даа.

Би бага сага хэтрүүлсэн байж магад, гэхдээ үнэний ортой. Үүнийг ямар ухаан гэх вэ. Нэг бол мань мэт нь ойлгож ухаарах аргагүй гоц төгс ухаан, нэг бол усан тэнэг явдал, өөрөөр бас нэрлэ дээ, уншигчид минь. Хэн ч албадаагүй, дарамтлаагүй байхад улаанбаатарчууд бид өөрсдийгөө автозамын түгжрэлд хав бариад хийчихлээ. Бүр хүлээд тавьчихлаа. Машин авч унахгүй бол “ална шүү” гэх заналхийлэл ядаж ганц ч монгол

хүнд хаа нэгтэйгээс ирээгүй юм гэнэ лээ. Машин худалдан авч барих нь аз жаргал уу, үйлийн лай юу, зовлонгийн далай юу. Үүнд ухаалаг хариулт олж хэл дээ!

Энэ их түгжрэл, түгжрэлийн бухимдал, цухалдал нэг л өдөр тэсрэлтэд хүргэнэ. Тэрийг нь цагдаа, хууль, шүүх зохицуулж чадахгүй л болов уу. Хойтонгоос төрийн гурван өндөрлөг Их тэнгэрийн амнаас нисдэг тэргээр ордны дээвэр дээр ирж буугаасай. Нийслэл хотод хувийн таксичин хийж яваа хэдэн зуун мянган жолооч нь “Тавьяат тээвэрчин” цол олгоод шар тэмдгээ хуу тараачихаад машинуудыг нь явуулахгүй арга сүвэгчилбэл (ихэнх нь актлагдана даа) яалтай билээ. Автомашины донг арилгахын тулд нэр хүндийг нь навс унагаж, автомашин унавал арай ялд унахгүй ч, гутартал нь, хоосортол нь дарамтлах л үлдлээ. Өөр хувилбар байхгүй болсон. Хоногтоо 300 машин хилээр орж ирдэг юм бол хойтон өдийд хоногт 500 машин болчихсон байхыг би бүр ёрлож байна. Малын хөлийн татвар гэж байсан шиг машины хөлийн татвар зохиож төр авах хэрэгтэй. Гадаадаас машин оруулж ирвэл өндөр татвар, машины дугаар өгөхдөө өндөр татвар, хэрэв долоо хоногийн бүх өдөр машинтайгаа заларна гэвэл бүр ч өдөр татвар, бямба, ням гаригт машинаа унана гэвэл арай бага татвар байж болж байна. Сард нэг сая төгрөг Замын цагдаад төлөөд сарын турш машинаа унаг, мөнгө хайран гэж байгаа бол ерөөсөө боль. Ингэж л шахахгүй бол болохгүй болчихлоо.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



tdbpay



Та энэхүү TDBPay QR кодыг дээрх дөрвөн банкны аппликейшн болон Most money QR үйлчилгээг ашиглан уншуулж, Засгийн газрын мэдээ сонины цахим хувилбарыг захиална уу.

● **Малын хөлийн татвар гэж байсан шиг машины хөлийн татвар зохиож төр авах хэрэгтэй.**

● **“Алтангадас” одонг хоёр сая төгрөгөөр аваад энгэртээ зүүсэн гэнэ. Нууц ханш нь энэ бололтой.**

● **Төрийн одон ингэлтээ доош орж үнэгүйдсэн юм бол төрийн одонгийн жагсаалтаас хасаад “Сонгуулийн одон” гээд зарлачихмаар юм.**

Нийслэл маань ердөө 10 мянган машины замын ачаалал даах чадалтай, гэтэл өдөрт 400 мянга буюу 40 дахин их төмөр хүлэг чихцэлдлээ. Улс эх орон маань автомашины түгжрэлийн өмнө гараа өргөлөө. Өөрөөр яах юм бэ. Авто машины донтонгуудыг энэ улс хэзээ нэг цэгцэлж, нийслэлийг минь чөлөөлөх бол хэмээн ард нийтээрээ бодож сэтгэж эхэлсэн байх. Тэгсэн л байх болтугай. Машинаа экспортод далдруулах нэг ухаалаг аргыг олж л таарна!

Inflation rate reaches four year high as meat prices soar

Inflation in Ulaanbaatar reached 10.5 percent.

Exporting coking coal price lowers

Soft coking coal prices decreased to USD 77.13 .

Analyst at Macquarie upgrades Turquoise Hill Resources stock

The company’s share prices increased by 8.5 percent to USD 0.47.

Top 20 index falls 1.21 percent, to 18,770.79 points

Market cap stands at MNT 2,47 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

President Battulga Khaltmaa meets with Mongolists who arrived Mongolia to take part in the international academic conference Bogd Khan 150 held under the auspice of the President of Mongolia.

ECONOMY


Share prices of Mandal Daatgal JSC, listed on MSE tier-I rating, hit lowest since 2019. The closing price was dropped 1.11 percent to MNT 4,921.

Under the program, Extended Fund Facility of the International Monetary Fund, the Bank of Mongolia plans to discontinue the mortgage loan and transfer it to the Government from January 1, 2020.

In the first nine months of 2019, the gross industrial output reached MNT 13.0 trillion, showing an increase of MNT 1.7 trillion from the previous year.

Total equilibrated revenue and grants of the General government budget amount to MNT 7.7 trillion and total expenditure and net lending amounts to MNT 7.3 trillion.

Top 20 index falls 1.21 percent, to 18,770.79 points. MSE A index decreases 1.12 percent, to 8,938.85 points. MSE B index drops 0.85 percent, to 7,374.05 points. Market cap stands at MNT 2,47 trillion.



SOCIETY

The nighttime electricity tariff discount will be available from November 1st.

The fourth Asian Public Housing Forum was held on Monday, within the framework of the 380th anniversary of the capital city, to find ways to address challenges to the development of government housing policies in Asian cities, increase citizen participation, exchange experience, and intensify cooperation.

The first international forum for nurses themed Mental Health Nursing was jointly organized by the Ministry of Health and the Mongolian Nurses Association with the support of the University of Essex of the U.K., and the postgraduate curriculum development team for psychiatric nursing.

The Mongolian University of Science and Technology (MUST) marks its 60th historic anniversary this year. Within the anniversary, University Presidents Forum to be held on October 15-16.

Inflation rate reaches four year high as meat prices soar



About three percent of the inflation rate was the meat price factor alone.

Gerelchuluun.J / ZGM©

Prices of meat and meat products increased by 37.2 percent

Aminaa.U
ZGM

The inflation rate reached nine percent nationwide which is the highest level since April 2015, exceeding the Bank of Mongolia

(BoM)’s target level. The key driver was the price of food and other products, according to the National Statistics Office (NSO) report. Particularly, the prices of meat and meat products increased by 37.2 percent from the end of the previous year.

About three percent of the inflation rate was the meat price factor alone. Also, apartments, water, electricity, gas, and other fuel prices increased by 11.3 percent. In Ulaanbaatar, inflation is higher than the national average, reaching 10.5 percent.

Current account deficit reached USD 807.5 million

The Monetary Policy Committee of the Bank of Mongolia held its meeting in September and left the policy interest rate unchanged at 11

percent, and General Economist of BoM explained, “Inflation growth is supply-sided and temporary”.

In the first nine months of 2019, total equilibrated revenue and grants of the General government budget amounted to MNT 7.7 trillion and total expenditure and net lending amounted to MNT 7.3 trillion, resulting a surplus of MNT 484.6 billion in the equilibrated balance.

General government budget expenditure and net lending were comprised of 79.6 percent of current expenditure, 18.2 percent of capital

expenditure and 2.2 percent of net lending. Current account deficit reached USD 807.5 million, which was mainly due to USD 1.0 billion deficit in services account and USD 1.0 billion deficit in the primary account.

In the reporting period, foreign trade surplus reached USD 1.3 billion, which increased by USD 415.5 million from USD 931.7 million year-on-year. In September 2019, foreign trade surplus totaled USD 51.4 million, which decreased by USD 180.2 million from August. [ZGM]

MINING

Coking coal price lowers



The average price of exporting coking coal in October was decreased to USD 119.66 per ton and soft coking coal prices to USD 77.13 from the previous month, the Ministry of Finance reported.

Mongolia Energy Corporation, one of the key coal exporting companies, is selling Khushuut port’s coal at USD 70 per ton. Coking coal prices may drop but soft coking coal price is likely to remain stable, according to the SouthGobi Sands JSC, which is exporting from Nariinsukhait port. Fenwei Energy analysts also say coking coal prices may decline in

2020 amid increasing demand.

The Ministry of Finance estimates that the average price of zinc in October is USD 2319.16 per ton. It increased by two percent from the previous month. The key exporter of zinc Tsairt Mineral LLC said that zinc is expected to increase over the remainder of the year.

The average price for copper in October was increased by 0.6 percent to USD 5744.99. Rio Tinto, one of the key exporters, believes that Oyu Tolgoi LLC will be enduring in the copper market over the next five years. However,

copper prices have fallen by more than 10 percent on the London Metal Exchange (LME) in the last half of 2019 due to the Trade War.

The aluminum price was estimated to be at USD 1749.23 in October, increased by USD 9. Goldman Sachs predicted that aluminum prices will surge its demand as prices continue to decline. According to the estimation, the aluminum price will be reduced to USD 1575 per ton in the next six months, which is lower than the current spot price of USD 200. [ZGM]

Turquoise Hill Resources stock upgrades

Analyst at Macquarie upgraded market rating for Turquoise Hill Resources, Oyu Tolgoi (OT) LLC’s investor, from Neutral to Outperform. Analysts cut the company’s benchmark interest rate by 46 percent for the past three months.

This was followed by the share prices increase of Turquoise Hill Resources. The company’s share

prices increased by 8.5 percent to USD 0.47 on the New York Stock Exchange (NYSE). It also increased by 8.6 percent to CAD 0.63 on the Toronto Stock Exchange (TSX).


OT’s investor expects the USD 5.3 billion underground expansion budget will have to increase by between USD 1.2 billion and USD 1.9 billion due to 16-30 months delays of the underground

mine project. Canaccord analyst considered it as the major concern of loan holders.


“Additional project financing will require the approval of the government of Mongolia, who could potentially use this as leverage to bolster their negotiating position,” Canaccord analyst Dalton Baretto told Australian Financial Review. [ZGM]

FX MARKET


USD/MNT rate
(One month to date)



RUB/MNT rate
(One month to date)



CNY/MNT rate
(One month to date)



Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

10.00	Эх орны төлөө
14.00	Робокон-2019
15.00	Алсын хараа 25: “Шинжлэх ухаан, Технологи, Инновац”
18.20	Монгол Улс, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд: “Их гүрний засаглал”
21.10	Цаг үе, үзэл бодол /шууд/
21.55	“Өмнөд тэнгист болсон явдал” ОАК 7-р анги

Bloomberg TV Mongolia

07.00	“Инновац 2050” нэвтрүүлэг
11.00	“Сая долларын суутан” нэвтрүүлэг
14.30	“Цахиурын хөндийгөөс цааш” нэвтрүүлэг
17.00	“Bloomberg Technology”
20.00	“Бүрэн тайлбар” нэвтрүүлэг
22.00	“Америкийн суутнууд” нэвтрүүлэг


БОЛОВСРОЛ HD

08.05	“Шидтэнүүдийн клуб хүүхэлдэйн кино 8.1-р анги
11.35	Солонгос хэлний алсын зайн сургалт /анхан шат/ 11-р хичээл
14.05	“Би багш” нэвтрүүлэг
17.40	“Монкард” хүүхэлдэйн кино 23-р анги
19.00	“Цэцэгсийн хөрөг” СОАК 4-р анги
23.05	Харанга - 30 жил “Замд гаръя” цуврал нэвтрүүлэг

МОНГОЛ TV

10.30	“Миний цорын ганц” СОАК 31-р анги
12.30	“Авьяаслаг Монголчууд шоу нэвтрүүлэг-2” /хагас шигшээ шалгаруулалт-3/
16.00	“Лусын хааны сүйт бүсгүй” СОАК 7-р анги
17.30	“Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн кино /season-3/ 1-4-р анги
21.00	“Намайг сонгооч-2” шоу нэвтрүүлэг дугаар 6
23.00	“Истанбулын нууц” Туркийн ОАК 17-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 17
Намрын дунд харагчин тахиа сарын нэг цагаан мэнгэтэй хөхөгчин тахиа өдөр
Үс засуулбал: Өнгө зүс доройтно
Наран ургах, шингэх: 07.10-18.06 цаг
Барилдлага: Арвидах
Шүтэн барилдлага: Хурьцахуй
Суудал: Уул

Аргын тооллын аравдугаар сарын 15, Ангараг гараг.
Билгийн тооллын 17, Гоё хүүхэн одтой, хөхөгчин тахиа өдөр.
Өдрийн наран 07.10 цагт мандан, 18.06 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, эзэл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Балжинням, Дашням давхацсан өлзийтэй сайн өдөр.



“Жаргалтай байх нь чухал” тоглолт
Хаана: Соёлын төв өргөө
Хэзээ: 2019.10.15
Тасалбарын үнэ: ₮16 мянга



“Тэнгэрийн хүү” жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.10.17-20
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



“Жаргагүй нар” жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.10.25-27
Тасалбарын үнэ: ₮15-25 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



ШИГШЭЭ БАГАА ШИЖИГНЭТЭЛ ДЭМЖЬЕ

2022 оны ДАШТ, 2023 оны Азийн АШТ-ий урьдчилсан шатны “F” хэсэгт өрсөлдөж буй Монголын шигшээ баг дөрөв дэх тоглолтоо Кыргызийн эсрэг хийхэд бэлэн болжээ. Гурав хоногийн өмнө талбайдаа Мьянмарын шигшээг 7:0-ээр хожсон тэд Монголын талбайгаас зөвхөн хожил авах зорилготой гэнэ. Кыргызийн шигшээ багийн дундаж нас 24. Мьянмарын хаалганд хет-трик

хийсэн Эдгард Андреевич Бернхардт нь Кыргыз, Герман гаралтай хөлбөмбөгчин. Тэрбээр Герман, Польш, Голланд, Финланд, Оман, Тайланд, Малайз зэрэг улсад тоглож явсан туршлагатай. Тэд 2019 оны Азийн аваргын шилдэг 16-д үлдсэн ч АНЭУ-д нэмэлт цагт 3:2-оор хожигдож байв. 2017 онд Монголын баг Кыргыztэй тоглохдоо 0:3-аар хожигдож байлаа. Тэгвэл манай шигшээ багийн давуу тал нь

өөрийн талбай, дээрээс нь хөгжөөн дэмжигчид. Гурав хоногийн өмнө Японы “Сайтама”-д 57 мянган үзэгч Монгол-Японы тоглолтыг үзсэн. Тиймээс “Талын хөх чононууд”-аа дэмжиж, 5000 хүний суудалтай Монголын хөлбөмбөгийн холбооны цэнгэлдэх хүрээлэнг битүү дүүргэе. Тоглолт өнөөдөр 16.00 цагаас эхлэх бөгөөд тасалбарын үнэ суудлаасаа хамаараад 5-50 мянган төгрөг байна.



Oyuna's Hit Songs
Хаана: Ulaanbaatar Palace
Хэзээ: 2019.10.18-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮16, 25 мянга



Symphony Jazz
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2019.10.18
Тасалбарын үнэ: ₮25 мянга




Харанга 30 жил-Замд гаръя
Хаана: Буянт-Ухаа спортын ордон
Хэзээ: 2019.10.19
Тасалбарын үнэ: ₮30-60 мянга


ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Х.15 10° -6° 5 м/с 4 м/с	Х.16 12° -4° 5 м/с	Х.17 12° -3° 6 м/с 5 м/с	Х.18 13° -1° 9 м/с 6 м/с	Х.19 4° -0° 11 м/с 9 м/с
Багавтар үүлтэй	Үүлшинэ	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Ялимгүй хур тунадас



ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Нас гүйцсэн агтланс эр хонь
- Манай оронд

элбэг байдаг харцгийн овгийн улайд дуртай махчин шувуу

3. Хонхор газар хуримтлагдсан цэнгэг болон давстай их ус

ХӨНДЛӨНГӨӨР:

- Эм тэмээ
- Ирвэсний зулзага
- Адуу илжигний эрлийз
- Эм үхэр
- 1.6 км-тай

тэнцэх хэмжээ 11. Улаан нүдэн гараг буюу нарны аймгийн дөрөв дэх гараг 14. Мал амьтны толгойд ургадаг ясан ургацаг

- Өвөл ороо нь ордог эцэг мал
- Нислэгийн хурдаараа дээд амжилт тогтоосон шавж

Өмнөх дугаарын хариу / 10.14

Ж	О	Н	С	О	Н	Ө	Ө	Д	Р	Ө	Г
И	О			О	И	Р	Э	В			
Д	А	Д	А	Р		Г	Ө	Л	Ө	Г	
О		О		О		Ө		Ү	Ө		
В	А	Н		В	О	Н		Ү	Е	Н	

ФОТО АГШИН



Монголын рок поп урлагийн домог болсон “Харанга” хамтлагийн 30 жилийн ойд зориулсан уран зургийн болон гитар, эд хэрэглэлийн үзэсгэлэн “Сэнгэраги арт” галерейд болж байна.


Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

ЗГМ: СҮДОКУ

	7			9		3
6	9			1		7
1		8	7			
		2				
			8			6
			5	2		9
	6				5	
8		9		7		
7		2		6		

3	8	7	6	5	2	1	4	9
6	1	9	8	3	4	2	5	7
5	4	2	9	7	1	3	8	6
2	6	5	7	1	9	8	3	4
9	7	4	3	2	8	6	1	5
1	3	8	5	4	6	9	7	2
4	5	6	1	9	3	7	2	8
7	9	1	2	8	5	4	6	3
8	2	3	4	6	7	5	9	1

(Index нийлбэрлэлт хөний)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	15.22	13.58
ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.55	20.10
БЭЭЖИН-УБ	21.10	23.40
УБ-ХОНКОНГ	06.25	10.55
ХОНКОНГ-УБ	12.05	16.45
УБ-СӨҮЛ	08.40	12.50
СӨҮЛ-УБ	14.20	17.00
БИШКЕК-УБ	04.15	10.00
УБ-БИШКЕК	11.00	13.25
БУСАН-УБ	08.35	11.40
УБ-БУСАН	13.00	17.35

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

“Интер авто линк” ХХК-ийн 3748836 дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

ЭДИЙН ЗАСАГ

Toyota устөрөгчийн машины борлуулалтаа 10 дахин өсгөнө

Цахилгаан машинтай харьцуулахад түлшний элементийн машин цэнэглэх хугацаа богино, туулах зай урт зэрэг давуу талтай. > 10

Онгоцны зорчигчийн суудлын дэлгэц хэрэглээнээс хасагдах цаг айсуй

Суудлын дэлгэцийг авч хаях шалтгаан нь хаа сайгүй хэрэглээ болж хувирсан ухаалаг утас. > 10

Li-Ning-ийн хувьцааны үнэ огцом өслөө

БНХАУ-д спортын хувцас загвар трэнд болж байгаа нь хувьцааны үнэ өсөх таатай нөхцөл бүрдүүлээ. > 10

Бослогын улмаас Хонконгт 100 зоогийн газар хаагдав



Эрик Лэм

Хэдэн сар үргэлжилсэн эсэргүүцлийн хөдөлгөөний улмаас 100 шахам зоогийн газар хаалгаа барилаа гэж Хонконгийн Сангийн сайд Пол Чан мэдээлэв. Тэрбээр энэхүү зогсолт 2000 орчим хүний ажил эрхлэлтэд нөлөөлсөн гэжээ. Түүнчлэн жижиглэн худалдааны зарим компани худалдааны цэгээ цөөрүүлэх, ажилтнуудаа цомтгох арга хэмжээ авсан байна. Үүгээр зогсохгүй спортын болон хөгжөөн цэнгээний арга хэмжээнүүд цуцлагдсан нь хотын нэр хүндэд сөргөөр нөлөөлснийг ноён Чан онцолжээ. Тэрбээр үл хөдлөхийн эздэд хандаж бизнес нь бослогын нөлөөнд автсан жижиглэн худалдаачдад түрээсийн хөнгөлөлт үзүүлэхийг уриалсан байна.

Орбан Унгарын нийслэлийг сөрөг хүчинд алдлаа



Золтан Саймон

Унгарын Ерөнхий сайд Виктор Орбаны нам Будапешт болон бусад томоохон дөрвөн хотод хяналтаа алдсан байна. Түүний нэг холбоотны садар самууны бичлэг тарсны дараа сонгогчид эрх баригчдад сануулга өгч, сөрөг хүчинд хотуудын эрх мэдлийн түлхүүрийг гардуулсан бололтой. Унгарын орон нутгийн сонгуульд сөрөг намууд санаандгүй хүчтэй өрсөлдсөн юм. Тэд олон жилийн зөрчлийн дараа нэгдэж,.... сөрөг хүчний нэгдсэн нэр дэвшигч гаргаж чадсан явдал амжилтад хүрэх үндэслэл болжээ. Будапешт хотын нэг дүүргийн захирагч асан, сөрөг хүчнээс нэр дэвшигч Гергели Караксони хотын удирдлагыг авснаар хамгийн чухал ялалт байгууллаа хэмээн мэдэгдэв.

Трамп Туркийн эсрэг хориг тавихад бэлэн гэжээ



Марк Никүэтт

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Туркийн цэргүүд Сирийн нутаг дэвсгэрт цөмрөн орсны хариуд Анкарагийн эсрэг хориг арга хэмжээ авахад бэлэн байна хэмээн мэдэгдэв. Өмнө нь Батлан хамгаалах яамны төлөөлөгч хэлэхдээ Ерөнхийлөгч Сирийн хойд нутагт байгаа Америкийн цэргийг төлөвлөгөөтэйгөөр гаргаж, аюулаас зайлуулах тушаал өгснийг мэдээлсэн. Ноён Трамп ням гарагт “БНН-ын сенатч Линдси Грэм болон бусад хууль тогтоогчтой арилцаж, Турк хэрээс хэтэрсэн ямар нэг үйлдэл хийвэл хатуу арга хэмжээ авах талаар зөвлөлдсөн” хэмээн твиттертэй бичсэн. Сенатч Грэм дараа нь Ерөнхийлөгчтэй уулзсанаа мэдээлээд энэ асуудлыг конгресс авч үзнэ гэсэн юм.

Трампын гар барилт эдийн засгийг сэргээх үү



Бээжин, Вашингтон хоёр оюуны өмч хийгээд амлалтыг хэрэгжүүлэх асуудалд мэдэгдэхүйц ахиц гаргах шаардлагатай.

◀1

АНУ-ын Худалдааны сайд Стивен Мнучин ням гарагт ABC телевизийн нэвтрүүлэгт оролцоходоо “Бидэнд хийх ажил маш их байна. Гэхдээ хоёр тал хүчин чармайлт гаргаж, энэ бүхнийг дуусгана гэдэгт итгэлтэй байна” хэмээн ярьжээ. Гэвч хөрөнгө оруулагчид эргэлзсэн хэвээ байгаа. Өнгөрсөн долоо хоногт худалдааны зөрчил намдах шинж мэдэгдэхэд АНУ-ын хувьцааны үнэ дээшилсэн боловч баасан гарагийн орой бодит байдалтай тулгарч, буцаад уруудав. Ноён Трампын “Манай улсын түүхэнд хамгийн том” хэмээн нэрлэсэн тохиролцоонд нэлээд дутагдал харагдана.

Уг асуудлыг жил гаруй ярилцсан

Бээжин энэ сард төлөвлөгдсөн тарифын өсөлтийг хойшлуулах шийдвэрийг Цагаан ордноор гаргуулж чадлаа.

хэдий ч ямар ч баримт бичигт гарын үсэг зурсангүй. Иймээс эдийн засагчид эргэлзээгээ илэрхийлж, 18 сар үргэлжилсэн худалдааны дайнаар доошилсон өсөлтийг сэргээнэ гэдэгт үл итгэсэн шинжтэй байна. Morgan Stanley-н стратегич Майкл Зезас, Мередит Пикетт нар “Өнөөгийн тарифыг багасгах арга замыг заасангүй. Тарифын өсөлт бол бодитой эрсдэл. Иймээс дэлхийн өсөлтийн төлөвийг дээшлүүлэх компанийн үйл ажиллагааны бодит сэргэлт гарна гэдэгт бид итгэхгүй байна” хэмээн бичжээ.

Австралийн шинжээч Реймонд Юнг “Саяын дэвшилийг үл харгалзан хурцадмал байдал мөддөө арилах шинж алга. Хэлэлцээ янз бүрийн шатанд үргэлжлэх явцад

эдийн засгийн эрсдэл байсаар байна” хэмээн анхаарууллаа. Тэрбээр “Хэлэлцээний 1-р шат гол төлөв ХАА-н худалдан авалт, тарифын хойшлуулалт ба зах зээл нэвтрэлтийг хамарлаа. Гэвч технологи шилжүүлэх ба үндэсний аюулгүй байдал зэрэг үндсэн асуудал руу орох хүртлээ ихээхэн саадтай тулгарна” гэж бичсэн байна.

Энэ мягмар гарагт ОУВС 2019, 2020 оны дэлхийн өсөлтийн төлөвийг дахин доошлуулж магадгүй байгаа. Зургадугаар сард тус сан дэлхийн эдийн засаг энэ онд 3.2, ирэх онд 3.5 хувиар өснө гэсэн таамаг нийтлүүлсэн нь төлөвийг 2018 оны 10 дугаар сараас хойш дөрөв дэх удаагаа доошлуулсан хэрэг юм. Ирэх баасан гарагт гаргах Хятадын ДНБ-

ий гуравдугаар улирлын тайлан есдүгээр сар хүртэл гурван сард өсөлт 6.1 хувьтай байсныг зарлах байх. Энэ нь сүүлийн 30 жилийн доод үзүүлэлт бөгөөд Хятадын удирдагчдын урт хугацааны төлөвлөгөөнд үл нийцэх хурдац юм.

Эдийн засагчдын энэ мэт өөдрөг бус таамгийг өөрчлөхийн тулд Бээжин, Вашингтон хоёр өнөөгийн хэлэлцээ болон 11 дүгээр сард болох Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны форум дээр оюуны өмч хийгээд амлалтыг хэрэгжүүлэх асуудалд мэдэгдэхүйц ахиц гаргах шаардлагатай. “Ийм нотолгоо бий болох хүртэл бид түр намжилтыг тодорхойгүй хэмээн дүгнэсээр байх болно гэж” Morgan Stanley-н стратегичид бичсэн байна.

Нууцлаг хувьцааны өсөлт Индонезид шинэ тэрбумтан төрүүлэв

Южун Ли

Индонезийн отгон тэрбумтан Нико Пурногомоос хувьцааны огцом өсөлт түүнийг хэрхэн баяжуулсан талаар асуухад түүний үл хөдлөхийн компани ашигтай байрлалд том төслүүдийг амжилттай гүйцэтгэж чаддаг явдал хэмээв. PT Pollux Properti компанийн гүйцэтгэх захирал хийгээд гол хувьцаа эзэмшигч 37 настай Нико “Хэрэглэгчдэд амласан зүйлээ хэрэгжүүлж чадах уу гэдэг түгшүүр байсан авч одоо үүнийг өөртөө баталж чадсан” хэмээн ярьжээ. Гэвч зах зээлийн ажиглагчид тийм ч итгэлтэй бус байна.

Эдний хувьцааны үнэ долдугаар сарын дундаас хойш 500 хувь өссөн суурь үзүүлэлт өөрчлөгдөөгүй ч тааруухан



арилжигдаж байсан хувьцаа гэнэт өссөний сүүлийн жишээ болов. Bloomberg-ийн дэлхийн индексэд багтдаг 4700 хувьцааг тэргүүлсэн Pollux Properti-ийн үнэлгээ 34 дахин өссөн явдал Индонезийн аж үйлдвэрийн дунджаас 10 дахин илүү гарчээ. Өнгөрсөн хугацаанд өдөр тутмын арилжааны дүн 70,000 орчим ам.доллар байсан нь үнэ өсөхөд онц нөлөөлөөгүй бололтой. Ciptadana Sekuritas сангийн захирал Жон Тежа “Эдний хувьцааны хөрвөх чадвар маш доогуур учир үнэ өссөн нь компанийн суурь үзүүлэлтийн илэрхийлэл биш” хэмээн

дүгнэжээ. Ийнхүү цаасан дээр бол Никогийн хөрөнгө 3.6 тэрбум ам.долларт хүрснийг Bloomberg Billionaires индексэд дурдсан байна. Тэрбээр компанийнхаа 85 хувийг хоёр холдингтоор дамжуулан эзэмшдэг. түүнчлэн Нико Сингапурт бүртгэлтэй гэр бүлийн үл хөдлөх хөрөнгийн Pollux Properties нээлттэй хувьцаат компанийн 90 хувийг эзэмшдэг аж.

Pollux Properti саяхан Жакартад Дэлхийн капитал тауэр босгосон нь хотын хамгийн өндөр барилгын нэг болжээ. Эдний гол хөрөнгө тансаг орон сууц, бизнесийн төв зэрэг ашигтай барилга барихад зарцуулагдаж байна. Pollux групп гэр бүлийн найз, Ерөнхийлөгч асан Хабибийн байгуулсан Meisterstadt компанийн 51 хувийг

эзэмшдэг. Никогийн эмээ өөрөө нэхсэн цамцаа заран аж төрдөг байжээ.

Одоо ч эдний гэр бүлийн бизнест нэхмэлийн Golden Flower нэртэй салбар бий. Calvin Klein, Zara, Muji зэрэг томоохон брэндүүдийн борлуулдаг болсон тус салбарынх нь хувьцаа зургадугаар сард анхдагч зах зээлд гарснаас хойш 800 хувь өсөөд байна. Гэр бүлийнхээ хөрөнгийн талаар ярихаас татгалздаг Нико Сингапурын их сургуулийн компьютерын хөдөлгөөнд төгссөн. Тэрбээр арлын улсад үл хөдлөхийн бизнесээ эхэлсэн боловч Индонезийн хүн ам өсөхийн хэрээр дэд бүтцийн хөгжил эрчтэй урагшилж буйг ажиглаад эх орондоо бизнесээ шилжүүлжээ.

Меркелийн төлөвлөгөөг гүрвэл, сарьсан багваахай саатууллаа

Эндрю Блэкман

Штутгарт хотод галт тэргээр ирсэн хүмүүсийг Германы хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд учирч буй бэрхшээлийг харуулсан асар том хонгил утгана. Энэ бол бүр 1990-ээд оноос мөрөөдөл болсон төмөр замын барилга боловч төсвөөс хэдэн тэрбум евро зарцуулаад дуусгаж чадалгүй төслийн хугацаанаас дөрвөн жилээр хоцорсон тул нэр хүндээ ч бас алджээ. Найман тэрбум еврогийн өртөгтэй Штутгарт-21 төслийн хоцролтын гол шалтгаан нь муу төлөвлөлт, гүрвэлийг хамгаалах экологийн хууль гэнэ. Иймэрхүү зохицуулалтын гох дэгээ Германд түгээмэл бөгөөд тус улсын өсөлт удааширч буйн нэг илрэл болдог. Daimler, Bosch зэрэг

ОУВС-ГААС ГАРГАСАН БАРИЛГЫН ЗӨВШӨӨРЛИЙН ИНДЕКС (Нэгжээр)	
Хонконг	1
Малайз	3
Арабын нэгдсэн Эмират	5
Шинэ Зеланд	6
Их Британи	17
Франц	19
Катар	20
Вьетнам	21
Норвег	22
Монгол	23
Герман	24
Швед	25
АНУ	26
Bloomberg©	

томчууд байрладаг Штутгарт хот Засгийн газрын дэмжлэгийг хүртэх зүй ёсны эрхтэй. Гэвч газар дээр байдал тийм ч амар бус. Хотын захиргааны төлөвлөлтийн хэлтсийн дарга Детлеф Крон санхүүжилт асуудал биш боловч байгаль орчны баримт бичгийн бүрдэл төслийн баримтаас гурав дахин зузаан байгааг хэллээ. Барилгын зөвшөөрөл авах үйл явц дөрөв, таван жилээр сунжирдаг гэнэ.

Иймээс эдийн засагт тустай дэд бүтэц болох төмөр зам, гүүр, утасгүй холбоо зэргийг сайжруулахад шаардлагатай зөвшөөрөл авах нь өөрөө бэрхшээл болж байгааг ноён Крон ярилаа. Канцлер Ангела Меркель саяхныг нэг уулзалт дээр “Германд хөрөнгө оруулалтын сан хангалттай бий.

Гэвч асуудал нь манай төлөвлөлт, батлуулах үйл явц аймшигтай удаан байна” гэсэн. Байгаль орчин, нийгэм, аюулгүй ажиллагааны шаардлагууд улам бүр нарийсаж, нэмэгдсээр буйн дотор галын зохицуулалт, ховор амьтдад нөлөөлөх үнэлгээ гэх мэтээс болж заримдаа хийгдсэн төлөвлөгөөг дахин засахад хүрдэг байна.

Дээр нь ийм маргаанаас үүдсэн шүүхийн заргуудыг нэмбэл хугацаа бүр сунаж өгнө. Штутгарт-21 төслийн талбай хамгаалалтад байдаг гүрвэл амьдардаг бүсэд тулсан тул нүүлгэхэд хэдэн сая евро шаардлагатай болжээ. Шлезвиг-Холштейн мужид авто зам барих гэтэл сарьсан багваахайд үзүүлэх нөлөөний үнэлгээг гаргаагүй учир эсэргүүцэлтэй тулгарсан

жишээ бий. Гадаадад инженерийн амжилтаараа гайхагддаг Герман улс дотоодын томоохон төсөл дээр хүч мөхөсдөхөд хүрдэг нь төлөвлөлтийн энэ олон шаардлагаас болдог байна.

Жишээ нь, Хамбург хотын концертын ордон, Берлиний нисэх буудал зэрэг төслүүд эцэс төгсгөлгүй зохицуулалтын саадтай тулгарчээ. Вауер AG барилгын компанийн захирал Майкл Стомберг “Маш хэцүү, цаг барсан төлөвлөлт ба батлуулах ажлын улмаас дэд бүтцийн чухал төслүүдийг заавал хоцроож гүйцэтгэх буюу дуусгаж чадахгүйд хүрч байна” гэжээ. Ийм бэрхшээл зөвхөн улсын төслөөр хязгаарлагдахгүй. Дэлхийн банкнаас гаргасан агуулах барих

гэх мэт арилжааны төслийн барилгын зөвшөөрөл авах индексээр Герман улс Серб, Франц, Малайз, Монголын дараа жагсаж байна.

Төлөвлөлтийн саадыг давлаа ч цаашлаад барилгын баг, тоног төхөөрөмж олоход бас өрсөлдөөн ихтэй. Германд барилгын салбар бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа учир салбарын бүх нэгжид ийм бэрхшээл тохиолддог. Гэхдээ иймэрхүү саад бэрхшээл салбарын хөгжлийг сааруулахгүй бололтой. ОУВС-гийн албаныхан эрх баригчдад хандаж, өнөөгийн татварын нөхцөлийг ашиглан өсөлтөө бэхжүүлэхийг уриалсан. Тус банк Германы эдийн засагт өгсөн үнэлгэндээ дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг эн тэргүүнд тавихыг сануулсан байна.

Эдийн засаг

Честер Доусон

Бусад авто үйлдвэрлэгчид зай хураагууртай SUV болон ачааны машины үйлдвэрлэлд анхаарч буй цаг үед Toyota Motor Corp устөрөгчийн хөдөлгүүрт седан машиныг ирээдүйгээ хэмээн тооцсоор.

Японы тэргүүлэх авто үйлдвэрлэгч түлшний элементийн технологи бүхий дөрвөн хаалгат Mirai седаныхаа хоёр дахь үеийн загварыг ирэх жилээс худалдаанд гаргаж, борлуулалтыг нь одоогийн загварынхаас 10 дахин өсгөхөөр төлөвлөж байна. Өрсөлдөгчид нь хэрэглэгчдийн худалдан авах дуртай зай багтаамж их том машинд зай хураагуур суурилуулж байхад Toyota компани устөрөгчийн седаныг масс зах зээлийн автомашин болж чадна хэмээн бооцоо тавьжээ.

АНУ зэрэг гол чухал зах зээл дэх эрэлт тодорхойгүйтэй уялдан Toyota дан цахилгаан хөдөлгүүрт машины үйлдвэрлэлд өрсөлдөгчөөсөө сүүл барьж яваа. Ирэх таван жилээс бүх загвараа цахилгаанжуулсан хувилбартай болгохын зэрэгцээ ирэх арван жилд дан цахилгаан хөдөлгүүрт 10 загвар гаргах тус компани устөрөгчийн хөдөлгүүрт машиныг ч хэрэглэгчдэдээ нийлүүлэх сонирхолтой.


“Toyota бүх бооцоогоо ганцхан технологид тавихгүй” хэмээн Умард Калифорнийн Гринсбород болсон брифингийн үеэр Toyota US группийн стратеги, төлөвлөлт хариуцсан дэд ерөнхийлөгч Даг Мурта тайлбарлаж байна. АНУ дахь Toyota-гийн төвийн ойрын хугацааны зорилт нь бензин-цахилгаан гибрид хүч дамжуулах ангитай автомашин ахиу үйлдвэрлэх. Одоогоор АНУ-ын зах зээлд гибрид зургаан загвар борлуулж буй Toyota ирэх оноос RAV4 кроссоверынхоо plug-in буюу цахилгааны сүлжээнд залгаж цэнэглэдэг гибрид хувилбарыг шинээр нэмнэ.

Toyota устөрөгчийн хөдөлгүүрт автомашиныг 20 гаруй жилийн өмнөөс хөгжүүлж ирсэн ч цэнэглэх дэд бүтэц, материал түүхий эдийн өндөр зардлаас болоод ахиц муу өдийг хүрчээ. Технологийн дэвшлийн ачаар

Toyota компани устөрөгчийн седаныг масс зах зээлийн автомашин болж чадна хэмээн бооцоо тавьжээ.



Toyota устөрөгчийн машины борлуулалтаа 10 дахин өсгөнө



устөрөгчийг хүчилтөрөгчтэй хольж цахилгаан үүсгэдэг түлшний элементийн стек төхөөрөмжийн зардал өдгөө тал хүртлээ буураад байна. Зардал буурсны дүнд Toyota 2018 онд 3,000-ыг үйлдвэрлэсэн ус төрөгчийн машинаа 2020 онд 30,000, 2025 он гэхэд 200,000 ширхэгт хүргэх гэж байгааг тус компанийн устөрөгчийн технологи хариуцсан захирал Тайёо Кавай Лондонд болсон хэвлэлийн хурлын үеэр сэтгүүлчдэд тайлбарлав.

АНУ-д General Motors, Европ тивд BMW AG зэрэг өрсөлдөгч нь ч устөрөгчийн элементийн технологид хөрөнгө оруулж байгаа. Гэхдээ эдгээр өрсөлдөгч одоогийн болоод ирээдүйн тэглаларалтай бүтээгдэхүүнээ дан

цахилгаан хөдөлгүүрт автомашин хэмээн эн тэргүүнд тавьж байгаа юм. АНУ-д ердөө Toyota, Honda Motor Co, Hyundai Motor Co гэсэн гуравхан үйлдвэрлэгч түлшний элементээр ажилладаг хөнгөн тэрэг борлуулдаг ч устөрөгчийн цэнэглэх станцын хүрэлцээнээс шалтгаалаад дилер цөөн.

Зай хураагуурт автомашинтай харьцуулахад түлшний элементийн хөнгөн тэрэг цэнэглэх хугацаа богино, бүтэн цэнэгээр туулах зай урт зэрэг давуу талтай. Гэвч ийм унаа дэлхийд жил бүр үйлдвэрлэж буй бараг 100 сая автомашины 0.1 хувь ч хүрдэггүйг АНУ-ын Шинжлэх Ухааны Үндэсний Академи тооцоолжээ. “Муу зүйл гэвэл олон жил сургаж, сурталчлаад байгаа хэрнээ

устөрөгчийн автомашин ихэнх хүмүүст нууцлаг хэвээрээ. Сайн зүйл гэвэл түлшний элементийн технологи яг одоогоос дэлхийд хэрэглээнд нэвтэрч эхэллээ” хэмээн Калифорнийн Гардена дахь Toyota-гийн судалгаа, хөгжүүлэлтийн төвийн ахлах инженер Жеки Бёрдсол тайлбарласан юм.


Устөрөгчийн шатахууны савны хэмжээг багасгах, түлшний элементийн стекүүдэд хэрэглэдэг өндөр үнэтэй цагаан алтны орцыг бууруулах тал дээр сүүлийн жилүүдэд ихээхэн дэвшил гарчээ. Цаашид цагаан алтыг хямд нийлэг материалаар орлуулах зэрэг шийдвэрлэх ёстой бэрхшээл их байгааг Карнеги Меллон Их Сургуулийн механик инженерийн профессор Шон Литстер өгүүлж байна.

Одоогийн Mirai загвар нь цэвэр алдагдалтай Toyota компани ирээдүйн сайжруулсан хувилбар хэзээнээс орлого оруулж эхлэх талаар тайлбар өгсөнгүй. Тус компани үйлдвэрлэлд бараг бэлэн болсон загварыг энэ долоо хоногт АНУ-ын Гринсбород сонирхуулахдаа албан ёсоор гарах товыг нь зарласангүй өнгөрлөө.

Анх 2014 онд гарсан анхны Mirai загвар ердөө Калифорни, Хавай муж улсад цөөн тоогоор зарагджээ. Калифорни муж улс сүүлийн хэдэн жилд устөрөгчийн цэнэглэх станцын сүлжээ байгуулахад 100 орчим сая ам.доллар зарцуулаад байна. Эгтгээд гадаад хэлбэр, 58,500 ам.долларын үнэ, салоны хийцийн дутагдлаасаа болоод нэгдүгээр үеийн Mirai-г дилерүүд амжилттай борлуулж дөнгөөгүй юм.

Сан-Диегод амьдардаг 42 настай Лоренс Копп хоёр жил бэрхшээл учруулсан Mirai машинаа бензин хөдөлгүүрт Ford SUV машинаар сольжээ. Устөрөгчийн цэнэглэх станц дэндүү цөөн, бүхээгийн зай нь бага насны хүүхдүүдтэй эцэгт жижигдээд байснаас компанийн захирал Копп машинаа зарсан юм.

Mirai-гийн шинэ загварыг Япон, Европ, АНУ-ын зэрэгцээ БНХАУ, Австрали, Ойрх дорнодын зарим улсад борлуулна.



БНХАУ-ын спортын барааны Li Ning компанийг үндэслэгч Ли Нин

Li-Ning-ийн хувьцааны үнэ огцом өслөө

Ричард Фрост

Хувьцааны зах зээлийн үнэлгээг нь авч үзэх юм бол яг одоогийн байдлаар дэлхийд спортын барааны хамгийн лут брэнд нь олимпын гимнастикийн аварга Ли Нин үндэслэн байгуулсан Хятадын компани болж байна.

Олимпын аварга өөрийн нэрээр байгуулсан компанийн хувьцааны үнэ энэ жил Хонконгод гурав дахин өсөж, MSCI Ази-Номхон далайн бүсийн индекст тэргүүлсэн төдийгүй хувцасны компаниуд дотроо шилдэг нь болов.

БНХАУ-д спортын хувцасны загвар улам бүр трэнд болж буй нь Li Ning-ий хувьцааны үнэ өсөх таатай нөхцөл бүрдүүлснийг Morgan Stanley тайлбарлав. Хөрөнгийн биржид тус компанийн зэрэглэл дээшилж, зөвхөн өнгөрсөн долоо хоногт хувьцааны нь үнэ 33 хувиар өслөө. Мөн АНУ-ын Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбоотой

(NBA) түнжин муудсантай уялдан БНХАУ-ын иргэд эх оронч зардал гаргах нь Li Ning-д ашигтай тусна хэмээн United Overseas Bank-ны Кэй Хян үзэж байна.

Хувьцааны үнэ огцом цойлох нь 2004 онд хөрөнгийн биржид бүртгэлтэй болсон тус компанийн хувьд анх удаагийнх биш. Стратегийн алдаанаас болж хувьцааных нь үнэ унаж, доод түвшинд олон жил үргэлжлэхээс өмнө 2007 болон 2010 онд Li Ning-ийн хувьцаа дээрхтэй адил цойлж байсан юм.

Хятадын эдийн засгийн удаашрал, худалдааны дайны сөрөг нөлөөнөөс зайлсхийхийн тулд хөрөнгө оруулагчид өнгөрсөн оны эцсээс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг илүүтэй сонирхох болсон нь ч хувьцааны үнэ өсөхөд түлхэц боллоо. Li Ning-ийн өрсөлдөгч Anta Sports Products Ltd-гийн хувьцааны үнэ ч энэ жил 87 хувиар өсөөд байна.

Онгоцны зорчигчийн суудлын дэлгэц хэрэглээнээс хасагдах цаг айсуй

Жастин Бахман

Агаарын зорчигч тээврийн компаниуд тийзийн үнээ өсгөнгөө зорчигчдыг талдаа татах гол арга нь бүхээгийн үйлчилгээ. Тэгвэл энэхүү талбар дахь нэг шируүн өрсөлдөөн таны шууд өмнө, зорчигчийн суудлын ард байдаг дэлгэцтэй холбоотой өрнөж байна.

Олон цагийг суудалд өнгөрөөх зорчигчийн тав тухын тулд ийм дэлгэцийг ихэвчлэн алсын нислэгийн том онгоцонд суурилуулдаг. Гэтэл АНУ-ын агаарын зорчигч тээврийн компаниуд дотоодын нислэгийн ганц эгнээ гудамтай (single-aisle jet) онгоцонд ийм дэлгэц суурилах байр суурь хоёр хуваагдав.

Онгоцны бүхээгт Wi-Fi холболт нэвтэрч, зорчигчид ухаалаг утас, таблетаараа кино, ТВ шоу үзэж, видео тоглоом тоглох нөхцөл бүрдчихээд байхад суудал бүрийн ард үнэтэй техник төхөөрөмж суурилуулах шаардлага багаслаа.

АНУ-ын агаарын нислэгийн гол гурван компани - American Airlines Group Inc, United Airlines Holdings Inc, Alaska Air Group Inc дотоодын нислэгийн, дунд зайн Boeing 737, Airbus A320 хөлгүүддээсээ суудлын дэлгэцийг нь авч эхэллээ. Boeing 737 хөлгүүд нь анхнаасаа суудлын дэлгэцгүй Southwest Airlines Co одоогийн бодлогоо хатуу баримтална гэдгээ хэдийн тайлбарласан.

Гэтэл Delta Air Lines Inc, Jet-Blue Airways Corp тэргүүтэй агаарын тээврийн компаниуд on-demand аудио-видео үйлчилгээтэй суудлын дэлгэц дотоодын зорчигчдыг татах чухал хэрэгсэл байх болно гэсэн тооцоотой. Delta Air Lines-ын Delta Flight Products салбар утасгүй холболтын стриминг үйлчилгээний программ



Суудлын дэлгэцийг авч хаях шалтгаан нь хаа сайгүй хэрэглээ болж хувирсан ухаалаг утас.

хангамж хөгжүүлж, уламжлалт утсан холболттой дэлгэцийн оронд суудалд бэхэлдэг таблет дэлгэцийг шинэ хөлгүүддээ суурилуулж байгаа.

Суудлын дэлгэц олон улсын зах зээлд ч хоёр чиг хандлагатай. Европ тивийн ганц эгнээ гудамтай агаарын хөлгүүдэд суудлын дэлгэц ховор. Гэтэл Ази тивийн цогц үйлчилгээтэй компаниудын онгоцонд суудлын дэлгэц энгийн зүйл.

Суудлын дэлгэцийг авч хаях шалтгаан нь хаа сайгүй хэрэглээ болж хувирсан ухаалаг утас. Бүхээгийн стриминг үйлчилгээг агаарын зорчигч тээврийн зарим компани зардлаа танах боломж гэж үздэг. Нөгөө талаар зорчигчийн урд талын суудлын ард байрлах дэлгэц алга болох нь зах зээлийн шинэ боломж хэмээн зарим компани ойлгож байгаа юм.

Суудлын дэлгэцээс татгалзаж буй компаниуд суурилуулах өндөр өртөг зардлаас гадна бусад шалтгааныг ч дурддаг. Ийм дэлгэц онгоцны хүндийн

жинг нэмж, шатахууны зардлыг ихэсгэдэг. Үүний зэрэгцээ технологийн шуурхай хөгжилтэй хөл нийлүүлж чаддаггүй болохоор зорчигчийн халаасанд яваа дивайстай харьцуулахад суудлын дэлгэц хоцрогдсон эд болж таардаг. “Хоёр гуравхан жилийн дараа хэрэггүй эд болно” хэмээн American Airlines-ын маркетинг хариуцсан захирал Курт Стаке шүүмжилж байлаа. (Гэхдээ Delta-гийн таблет дэлгэц хялбархан солих боломжтой!)

Өдгөө American Airlines-аар үйлчлүүлэгчдийн талаас илүү нь хоёр цахим дивайстайгаар зорчигчдын бүхээгт нэвтэрч байгааг захирал тайлбарласан юм. Үр дүнд нь зорчигчид суудлын дэлгэцийг бус, гарын тухтай өргөн түшлэг, цахилгааны залгуур байгаа эсэхийг илүү асуудаг болсныг судалгаа харуулжээ. Тус компани ганц эгнээ гудамтай агаарын хөлгүүдийнхээ ихэнхийг хиймэл дагуулын өндөр хурдтай интернэт холболтоор тоноглоод байна.

Суудлын дэлгэц дэмждэг ком-

паниуд ч үйлчлүүлэгчтээ татах өөрийн аргатай. JetBlue-гийн зорчигчдод өргөн зурвасын Wi-Fi үйлчилгээ үнэгүй. Delta Air Lines ч ирэх жилээс үнэгүй Wi-Fi нэвтрүүлнэ. “Онгоцны бүхээгт зорчих нь газар дээрх шиг амьдрал зогсчихно гэсэн үг биш. Хүн гэртээ байдагтай адил орчныг л бид үүсгэх гээд байгаа юм” хэмээн JetBlue-гийн бүтээгдэхүүн хариуцсан захирал Мария Стоянова тайлбарласан юм. Зорчигчид агаарт дунджаар гурван цагийг өнгөрөөдөг учраас “энтертэйнмент чухал”-ыг Delta-гийн гүйцэтгэгч захирал Эд Бастиан онцлон өгүүлж байна.

Суудалд дэлгэц байх, байхгүйгээс үл шалтгаалан агаарын тээврийн бүх компани зорчигч нэг бүрт тусгайлан зориулсан, илүү хурдтай Wi-Fi үйлчилгээ нэвтрүүлэхэд анхаарах боллоо. “Газраас дээш 12,000 метрийн өндөрт гутал, хүнс худалдаж авах нь энгийн зүйл болно” хэмээн Global Eagle Entertainment-ын дэд захирал Майк Пиготт үзэж байна.

Эдийн засаг

Сурталчилгаа түгээх сувагт бус контентын агуулгадаа мөнгө зарах хэрэгтэй

Монгол Улс зах зээлд шилжсэн 30 орчим жилийн хугацаанд олон улсын брэнд бүтээж чадаагүй

Б.Дашням
Монголын маркетингийн холбооны ерөнхийлөгч Ш.Алтанбаганатай ярилцлаа. Хүмүүс хэрэггүй мэдээллийг хүлээж авах сонирхолгүй болсон өнөө үед тэдэнд хэрэгтэй контентоор дамжуулж, бараа бүтээгдэхүүнээ хүргэх нь чухал болохыг тэрбээр онцолж байна.

–Смарт маркетингийн арга хэмжээ тав дахь жилдээ болох гэж байна. Гэхдээ маркетинг гэдэг байнга хувьсан өөрчлөгдөж байдаг зүйл. Маркетингийн суурь ойлголтууд хэрхэн өөрчлөгдөж байгаа вэ?

–Маркетинг гэхээр тодорхой мессежийг гоёор хүргэх гэсэн уламжлалт хандлага байсан. Гэхдээ энэ салбар тэр чигтээ өөрчлөгдөж байгаа. Зөвхөн маркетинг гэлтгүй бүтээлч үйлдвэрлэлийн салбар их өөр болж байна. Үүнд нөлөөлж буй хүчин зүйл нь технологийн дэвшил. Технологийн шинэчлэлийн хүрээнд хэрэглэгчийн болон хүмүүсийн мэдээллийг иж бүрэн хүлээж авах нөхцөл бүрдэж байгаа. Үүн дээр тулгуурлаад хэрэгцээтэй байгаа бүтээгдэхүүнийг хүнд хүргэх боломжтой. Өөрөөр хэлбэл, дэлхийн эдийн засаг туршлагын эдийн засаг руу орж байна. Гоё ганган мессеж, дуулиан шуугианаар дамжуулан зар сурталчилгаа хийх биш хүнд

бодитой, хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг ямар байдлаар хүргэх вэ гэдэгт анхаарах болсон. –Маркетинг нь хүний тархинд хоногшуулах чиглэлд анхаардаг болсон гэж байна. Гэвч арван жилийн өмнө л рекламанд тоглодог байсан хүмүүсээ тоглуулаад, яг тэр хуучин хэлбэрээрээ хийсэн сурталчилгаа гарсаар л байна. Монголын зах зээлд энэ өөрчлөлтийг буулгахад хэт өндөр зардалтай учир хуучин загвараар маркетинг хийсээр байна уу?

–Монгол Улс импортын эдийн засагтай. Уул уурхайн бүтээгдэхүүн экспортолдог. Дэлхийн бараа бүтээгдэхүүний зах зээлд том тоглогч биш. Уул уурхайн их тэрсэлтийн дараа бид ер нь ямар бараа бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд зарах вэ, дотооддоо яаж ажиллах вэ гэдэг асуулт салбарынхны өмнө тавигдаж байна.

Монголын бүтээлч үйлдвэрлэлийн салбар маш их өөрчлөгдөж байгаа

Нүдэнд харагдахгүй байгаа ч сүүлийн гурав, дөрвөн жилийн хугацаанд Монголын бүтээлч үйлдвэрлэлийн салбар маш их өөрчлөгдөж байгаа. Тэд эхний ээлжинд суралцах нь хамгийн чухал. Дэлхийтэй нэг хэлээр ярьдаг, нэг янзаар ойлгодог болох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, манай бараа бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд өрсөлдөхийн тулд гадагшаа гарч эхэлж байгаа. Дотооддоо

бол хүний анхаарлыг татсан, хошин марзан сурталчилгаа хийдэг хандлага хэвэрээ байна. Гэхдээ сууриараа гадагшаа гарч эхэлж байгаа бөгөөд дотооддоо ч нийгмийн асуудлыг шийдсэн олон нийтийн кампанит ажлууд нэмэгдэж байгаа. Энэ бол дэлхийн хөгжил рүү тэмүүлэх, дотооддоо нийгмээ өөрчлөх хандлага нэмэгдэж буйн илрэл.

–Хувийн хэвшилд ажиллагсад сошиал нөлөөлөгчдийг ирээдүй гэж хардаг. Монголын нөхцөлд энэ маркетинг хэр амь бөхтэй байх бол. Монголд нөлөөлөгчид бас тийм олон биш байна.

–Tesla, Apple зэрэг компанийг харахаар харилцаа холбоо гэхээс илүү бүтээгдэхүүний инновацид маш их маркетингаа төвлөрүүлж байна. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүнийг хэрэглэгчид тустай, өгөөжтэй, үнэ цэнтэй байх чиглэлд зорьж байгаа юм. Энэ ч утгаараа харилцаа холбооны мессежүүд ач холбогдлоо улам алдаж байна. Илон Маск хэлэхдээ “Бидэнд харилцаа холбооны зар сурталчилгаанд зарцуулах мөнгө байхгүй” гэсэн. Монголын зах зээлд ч гэсэн тийм хандлага гарч байна. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний инновацид илүү их анхаарал хандуулах болсон.

–Сүүлийн жилүүдэд дэлхий даяар телевиз, сонины сурталчилгаа нэлээн хумигдсан. Сошиал сурталчилгаа идэвхтэй байгаа ч хэт их болохоор хүмүүс үзэхээ больж байх шиг байна. Тэгэхээр сурталчилгааг аль платформ дээр байршуулах нь илүү үр дүнтэй вэ?

–Телевиз, сонин гэсэн уламжлалт талбарын тоо улам багасаж байна. Үүний оронд дижитал сувгууд маш олон хүний хэрэглээ болж байгаа. Гэхдээ зар сурталчилгааны сувгийн сонголтоос илүү тухайн бүтээг-

дэхүүний талаар өгч буй мессежийн агуулгад ихээхэн анхаарах хэрэгтэй болсон. Хүмүүс хэрэггүй мэдээллийг хүлээж авах сонирхолгүй болчихсон. Зүгээр л үзэгдэл болсон. Тиймээс хүмүүст хэрэгтэй контентоор дамжуулж, өөрийн бараа бүтээгдэхүүнийг хүргэх нь хамгийн чухал. Зар сурталчилгааны сувагт мөнгө үрэхээс илүү контентын агуулгадаа мөнгө зарах хэрэгтэй.

● **Илон Маск хэлэхдээ “Бидэнд харилцаа холбооны зар сурталчилгаанд зарцуулах мөнгө байхгүй” гэсэн.**

● **Тайланд улс гэхэд “Инээмсэглэж буй Тайланд орон” гэдэг төслийг 30 жил хэрэгжүүлсэн.**

● **Брэнд гэдэг бодит бүтээгдэхүүн гэхээс илүү бүтээлч үйлдвэрлэл, хил хязгааргүйгээр олон улсад гарах боломж юм.**

–Дотоодын зах зээлээс гадна улсынхаа хэмжээнд энэ салбарт тавьж буй зорилго бол бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх. Зөвхөн уул уурхай дээр суурилагаас илүү шинэ эдийн засагтай болох зорилготой. Үүн дээр маркетингийн салбар

ямар үүрэг хүлээж байгаа вэ?

–Бид нэг зүйлийг ойлгох ёстой. Монгол Улс зах зээлд шилжсэн 30 орчим жилийн хугацаанд олон улсын брэнд бүтээж чадаагүй. Үүнд хоёр асуудал бий. Эхнийх нь Монгол Улс гэх брэнд. Монгол Улс юугаараа дэлхийд танигдах вэ гэдэгт анхаарч ажиллах ёстой. Мэдээж тодорхой санаачилгууд гарсан. Төр, хувийн хэвшил, олон нийтийг хамарсан маш тогтвортой бүтэц үүнд хэрэгтэй. Улсын брэнд гэдэг арав, хорин жилийн турш тууштайгаар тодорхой дүр төрх бүтээхийг хэлдэг. Тайланд гэхэд “Инээмсэглэж буй Тайланд орон” гэдэг төсөл 30 жил хэрэгжүүлсэн. Тиймээс янз бүрийн сувгаар явж буй замбараагүй мэдээллүүд дунд “Монгол бол ийм орон юм” гэдэг мессежийг бүтээх ёстой. Хоёрдугаарт, Монгол Улс олон улсын брэнд яаж гардаг вэ тэр аргаар л гарах ёстой. Түүнээс биш энд тэндхийн экспод орж, бараа бүтээгдэхүүн зарснаар хүнд хүргэж чадахгүй. Мэдээж аль салбар илүү өрсөлдөх чадвартай вэ гэдэг зах зээлээ судлах хэрэгтэй. Тухайлбал, Монголын уламжлалт соёл олон улсад брэнд болж гарах боломж маш их. Монгол соёл брэнд болж чадна гэдгийг The Ни хамтлагийн амжилтаас харж болно. Тэгэхээр уламжлалт соёл гэдэг ямар нэгэн байдлаар олон улсын хэмжээнд хүрэх боломжтой юм. Мэдээж аялал жуулчлалын салбар манайд байгаа бас нэгэн боломж. Сүүлийн үед технологийн чиглэлээр олон улсад гарах хугцэл эрмэлзэл монголчуудад байна. Үүнийг бид дэмжих ёстой. Тэгэхээр брэнд гэдэг бодит бүтээгдэхүүн гэхээс илүү бүтээлч үйлдвэрлэл, хил хязгааргүйгээр олон улсад гарах боломж юм.

ЗГМ ТОВЧХОН

» **ТОО**

543

Сая ам.доллар. Warner Bros Pictures-ийн бүтээл, сэтгэхүйн триллер төрлийн Joker кино Box Office-ийн жагсаалтыг дахин тэргүүлээ. 60 сая ам.долларын зардлаар бүтсэн энэхүү кино олон улсад нээлтээ хийснээс хойш 12 өдрийн дотор орлого нь 543 сая ам.доллар давсан байна.

» **ХАНШ**

Ам.доллартай харьцах төгрөгийн ханшийг Монголбанк 2,669.96 гэж зарлалаа. Энэ нь төгрөг ам.долларын эсрэг 0.01 хувиар чангарсан үзүүлэлт аж.

» **НӨӨЦ**

688.7

Сая ам.доллар. Наймдугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ жилийн өмнөхөөс 30 орчим хувиар өсөж, гурван тэрбум 688.7 сая ам.доллар хүрээд байна. Сарын дүнгээр нь авч үзвэл валютын нөөц хоёр орчим хувиар өсөөд байгаа юм.

» **ТӨСӨВ**

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний есөн сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.7 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.3 их наяд төгрөг болжээ.

» **ТҮНШ**

БНКаЗУ-ын нийслэл Нур-Султан хотноо зохион байгуулагдсан “Монгол Казахстан бизнес форум”-ын үеэр 200 орчим сая ам.долларын дүнтэй найман хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулагдсаныг МҮХАУТ-ийн Ерөнхийлөгч О.Амартүвшин өгүүллээ.

» **ХӨРШ**

БНХАУ-ын агаарын бохирдлыг бууруулах бодлогын хүрээнд гангийн үйлдвэрүүдийн гарцыг хязгаарлаж эхэлснээр төмрийн хүдрийн эрэлт буурлаа. Гол гангийн үйлдвэрүүд байрладаг Таншань, Линфень хотод энэ сараас хориг хэрэгжих эхэлснээр төмрийн хүдрийн үнэ буурч эхлэв.

» **УУЛ УУРХАЙ**

1.8

Хувь. Олон улсын зах зээлд WPI төрлийн газрын тосны ханш 1.8 хувиар буурч, 53 ам.долларт хүрсэн бол Brent-ийн ханш төдий хувиар багасаж, 59 ам.доллар давлаа.

» **ТҮҮХИЙ ЭД**

1.7

Хувь. Лондоны металлын биржид хөнгөн цагааны ханш 1.7 хувиар буурч, тонн нь 1722 ам.долларт хүрсэн бол цайрын үнэ 1.3 хувиар өсөж, 2419 ам.доллартай тэнцэв.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,669.96
Евро	2,939.89
Японы иен	24.74
ОХУ-ын рубль	41.59
БНХАУ-ын юань	376.07
БНСУ-ын вон	2.25

САНХҮҮ

Цахим төлбөр тооцооны зах зээл 2023 онд \$87 тэрбум хүрэх төлөвтэй

Олон улсын цахим төлбөр тооцооны зах зээл 2018-2023 онд 18 хувиар өсөж, 87 тэрбум ам.доллар хүрэх төлөвтэй гэж Reporterlinker компани мэдээлж байна.

Ялангуяа гар утасны болон

contactless төлбөр тооцооны гүйлгээ 46 тэрбум еврог давсан бол картаар хийгдсэн гүйлгээ цахим төлбөр тооцооны 21 хувийг бүрдүүлж байгаа аж. Улс орнуудаар нь харвал британичууд төлбөр

тооцооныхоо гуравны нэгийг бэлэн мөнгөөр хийж байна. Хэдий тийм боловч 2027 онд энэ тоо 16 хувь хүртэл буурна гэж Их Британийн банк, санхүүгийн худалдааны ассоциаци тооцоолж байна. Харин Шведийн төв

банкны мэдээлснээр тус улсад нийт төлбөр тооцооных нь ердөө хоёр хувийг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байгаа аж. Үүний зэрэгцээ цахим худалдааны дүн 2022 он гэхэд 4.6 их наяд ам.доллар давах төлөвтэй гэж

Worldpay-ээс танилцуулсан дэлхийн төлбөрийн системийн тайланд дурджээ. Одоогоор цахим худалдааны гүйлгээний талаас илүү хувийг кредит болон дебит картын гүйлгээ бүрдүүлж байгаа юм.

УУЛ УУРХАЙ

Сангийн яам аравдугаар сарын коксжих нүүрсний экспортын үнийг бууруулав

Т.Элиса
Шинжээч

Нэг тонн коксжих нүүрсний аравдугаар сарын экспортын дундаж үнийг 119.66 ам.доллар, сул коксжих нүүрсний үнийг 77.13 ам.доллараар тооцож, өмнөх сарынхаасаа бууруулсан талаар Сангийн яам мэдээллээ.

Гол экспортлогч компанийн нэг Mongolia Energy Corporation Хөшөөтийн нүүрсийг нэг тонн тутамд нь 70 гаруй ам.доллараар борлуулж байгаа талаар мэдээлсэн юм. Коксжих нүүрсний үнэ буурах эрсдэл байгаа ч сул коксжих нүүрсний үнэ тогтвортой байх төлөвтэй гэж Нарийнсухайтаас

экспорт хийж байгаа “Саусгоби сэндс” ХХК таамаглаж байна. Коксжих нүүрсний нийлүүлэлт нэмэгдэхтэй зэрэгцээд 2020 онд үнэ буурна гэж Fenwei Energy-ийн шинжээч таамаглаж байна.

Харин нэг тонн цайрын аравдугаар сарын экспортын дундаж үнийг 2319.16 ам.доллар гэж Сангийн яам тооцоолсон байна. Энэ нь өмнөх сарынхаас хоёр хувиар нэмэгджээ. Цайрын үнэ оны үлдсэн хугацаанд нэмэгдэнэ гэж найдаж байгаа талаар гол экспортлогч “Цайрт минерал” ХХК мэдэгдлээ. Зсийн аравдугаар сарын экспортын дундаж үнийг 0.6 хувиар нэмж, 5744.99 ам.доллараар тооцсон байна. Гол экспортлогчийн нэг “Оюу Толгой”-н хөрөнгө

оруулагч Rio Tinto компани ойрын таван жилд зэсийн зах зээл тэнцвэртэй байна гэж таамаглаж байгаа юм. Хэдий тийм боловч худалдааны дайнаас үүдэлтэйгээр сүүлийн хагас жилд зэсийн үнэ Лондоны Металлын биржид 10 гаруй хувиар буурсан байна.

Нэг тонн хөнгөн цагааны аравдугаар сарын экспортын үнийг есөн ам.доллараар нэмж, 1749.23 болгон тооцоолжээ. Цаашид хөнгөн цагааны нийлүүлэлт эрэлтээсээ давж өсөх учир үнэ буурна гэж Goldman Sachs таамагласан байна. Ойрын зургаан сард тонн тутмынх нь үнэ 1575 ам.доллар руу буурна гэсэн нь одоогийн спот ханшаас 200 орчим ам.доллараар бага дүн юм.

ХУВЬЦАА

Turquoise Hill Resources-ийн хувьцааны үнэлгээг ахиулав

Т.Элиса
Шинжээч

Macquarie-ийн шинжээч Хэйдэн Бэйрстоу “Оюу Толгой”-н хөрөнгө оруулагч Turquoise Hill Resources-ийн хувьцааны үнэлгээг Neutral байсныг Outperform болгон нэмэгдүүлсэн байна. Шинжээчид сүүлийн гурван сард Turquoise Hill Resources-ийн хувьцааны нэг жилийн зорилтот ханшийг 46 хувиар бууруулсан юм.

Энэхүү мэдээллийн дараа Нью-Йоркийн Хөрөнгийн биржид Turquoise Hill Resources-ийн хувьцааны ханш 8.5 хувиар өсөж, 0.47 ам.доллар болсон байна. Харин Торонтогийн хөрөнгийн

биржид мөн л 8.6 хувиар өсөж, 0.63 канад доллар боллоо.

“Оюу Толгой”-н гүний уурхайн анхны олборлолт эхлэх хугацааг 16-30 сараар хойшлуулж, хөрөнгө оруулалтын зардлыг 1.2-1.9 тэрбум ам.доллараар нэмж магадгүй гэж хөрөнгө оруулагч тал мэдээлж байгаа юм. Энэ нь гол зээлдэгчдийн анхаарах асуудал болсон гэж Capascore-ийн шинжээч дүгнэсэн байна.

“Нэмэлт санхүүжилт хийхээр бол Монгол Улсын Засаг эстий газрын зөвшөөрлийг авах ёстой. Харин Засгийн газар үүнийг өөрсдийн хэлэлцээрт давуу тал болгон ашиглаж магадгүй” гэж шинжээч үзсэн талаар Australian Financial Review мэдээлжээ.

Эдийн засаг

Монгол Улс “Саарал жагсаалт”-д орох эсэхийг өнөөдөр шийднэ



Хэрэв бид уг жагсаалтад орвол төгрөгтэй харьцах ам.долларын ханшаар дамжуулж импортоор түлхүү авдаг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үнэ өсөхөөс гадна олон улсын зах зээлээс босгосон шил шилээ дарсан бондуудын өр төлбөр нэмэгдэнэ.



Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

Зээлжих зэрэглэл буурч, хөрөнгө оруулалт хумигдана

◀1 Ийм нөхцөлд итгэл найдвар тун бага харагдаж байна гэдгийг тэд зориуд онцолжээ. Монгол Улс 2013 онд “Саарал жагсаалт”-д орж байсан удаатай. Энэхүү жагсаалтаас гарахын тулд Мөнгө угаахтай тэмцэх талаар хууль, эрх зүйн орчноо сайжруулахаар болж, зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулснаар 2014 онд тус жагсаалтаас хасагдаж байсан түүхтэй. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авдаг байгууллагын зүгээс манайхыг “Хар жагсаалт”-д орсон улстай эдийн засгийн харилцаа өрнүүлэх нь зохимжгүй гэж үзсэн. Хэрэв удаан хугацаанд энэхүү харилцаа үргэлжилсээр байвал хариуцлага тооцох хэмжээнд асуудал хүндэрнэ гэж мэдэгдсэн нь нэг бус. “Хар жагсаалт”-д Иран болон Хойд Солонгос буюу БНАСАУ орсон бөгөөд манай улсын хувьд Хойд Солонгосоос ажиллах хүч авахаас гадна зэвсэг техникийн наймаа хийдэг гэсэн хэрэгт унасан билээ. Эдгээр нь “Саарал жагсаалт” руу хөтлөх шалтгааны зөвхөн нэг хэсэг. Хойд Солонгос олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын “Хар жагсаалт”-д багтсан тул иргэд нь дэлхийн бусад улс оронд ажиллах эрхгүй болж



эхэлсэн.

“ХАР ЖАГСААЛТ” Ч БИДЭНД ОЙРХОН БАЙНА Монгол Улс 2004 онд Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын гишүүн улс болж, үүнээс хоёр жилийн дараа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталсан. Гишүүн улс орнууд 40 зөвлөмжийг дагаж мөрдөх учиртай бөгөөд манай улс 2016 онд хийсэн үнэлгээгээр үүний 20 зөвлөмжийг хангалтгүй мөрдсөн тул 2017 онд эрчимтэй хяналтад орж, хугацаатай үүрэг даалгавар авсан. Үүний хэрэгжилтийг өнөөдөр Парист

хэлэлцэх гэж байна. Энэ үеэр Монгол Улс “Саарал жагсаалт”-д орох эсэхийг шийдэх юм. Манай улс хангалтгүй 20 зөвлөмжөөс гадна үр дүнтэй байдлын 11 үзүүлэлтээс бүгдэд нь хангалтгүй үнэлгээ авсан. Өөрөөр хэлбэл, “Саарал жагсаалт” бидний өмнө тун ойрхон байна. Хэрэв бид уг жагсаалтад орвол төгрөгтэй харьцах ам.долларын ханшаар дамжуулж импортоор түлхүү авдаг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үнэ өсөхөөс гадна олон улсын зах зээлээс босгосон шил шилээ дарсан бондуудын өр төлбөр нэмэгдэнэ. Тэрчлэн зээлжих зэрэглэл уруудаж, өр төлбөрөө дахин санхүүжүүлэх

боломж улам хумигдах эрсдэлтэйг холбогдох албаныхан хэлж байна.

ГАДААДАД БҮЙ МОНГОЛЧУУДАД ХҮРТЭЛ “СААРАЛ ЖАГСААЛТ” НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТЭЙ

Төв банкны зарласан албан ханшаар ам.доллар 2669 төгрөгтэй тэнцэж буй. Эдийн засагт учрах хамгийн гол аюул нь олон улсын байгууллагууд манай улстай хамтран ажиллахаас татгалзах, гадаадын харилцагч банк харилцаагаа таслах, жилээс жилд дундарч байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалт багасаж, гадаад худалдааны хэмжээ буурах бодит эрсдэл байна. Тэрчлэн гаднын орнуудад ажиллаж амьдарч буй монголчуудад хүртэл энэ нь ихээхэн хамааралтай бөгөөд “Саарал жагсаалт”-д багтсан орны иргэдийг хүлээн авч ажиллуулахаас татгалзах, нутаг буцаах хүртэл арга хэмжээ авч болзошгүй аж.

Мөн иргэд гадаадад картаар гүйлгээ хийх боломжгүй болж, гадаад гүйлгээний шилжүүлэг хийхэд хүндрэл үүсэх, улмаар эдийн засаг агших, иргэдийн амьдрал доройтох эрсдэлтэйг Санхүүгийн зохицуулах хороо болон төв банкныхан мэдээлсэн юм.

МӨНГӨН ШИЛЖҮҮЛГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖҮҮЙ БОЛНО УИХ-ын дарга холбогдох албаныхантай уулзах үеэр “Үй олноор хөнөөх зэвсэг

дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай” хуулийн төслийг ойрын үед УИХ-аар хэлэлцэн батлахаар болжээ. Мөн хар тамхи зөөвөрлөх, наймаалах хэрэгт төрийн албан хаагчид нь холбогддог, хил гаалиар алт зэрэг хориотой бараа бүтээгдэхүүн нэвтрүүлдэг байдлыг зогсоох талаар арга хэмжээ авахаа парламентын

спикер мэдэгджээ. Тэрчлэн авсан арга хэмжээнийхээ талаар олон улсын байгууллагад захидал хүртэл илгээхээр болсон билээ. Манайх үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлж, терроризмыг санхүүжүүлдэг орон биш. Гэвч энэ жагсаалтад ороход тухайн асуудлыг хариуцсан байгууллага, албан тушаалтан ажил үүрэгтээ хариуцлагагүй хандсанаас ийм байдалд хүрсэн гэсэн дүгнэлтэд хүрчээ. “Нэр хугарахаар яс хугар” зүйр үг байдаг. Олон улсад Монгол Улс нэр нүүрээ хадгалж үлдэх эсэх нь тун эгзэгтэй байна. Бид “Саарал жагсаалт”-аар зогсохгүй “Хар жагсаалт” руу унаж мэдэх нь. Авлигатай тэмцэх газраас мэдэгдсэн 11 их наяд төгрөгийн авлигын хэрэг ч үүнд нөлөөлж байна.

Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль 2015 онд батлагдсаны дараа 35 их наяд төгрөгийн эх үүсвэр ил гарч ирсэн. Монгол Улсын ДНБ-ээс 1.5 дахин их хэмжээтэй хөрөнгө мөнгө илэрсэн нь Монгол Улс татвараа авч чаддаггүй, мөнгө угаадаг юм байна гэсэн ойлголтыг олон улсад өгсөн. Үүнээс гадна 500 гаруй банк бус санхүүгийн байгууллага, 2000 орчим хадгаламж зээлийн хоршоонд хяналт тавих хэмжээний боловсон хүчний нөөц хангалтгүй байгаа нь “Саарал жагсаалт” руу түлхжээ. Энэ жагсаалтад орсноор гадаад мөнгөн шилжүүлгийн гүйлгээ хийх боломжгүй болох, шалгалт улам чангарах, буцаах зэрэг олон эрсдэл бидний өмнө байна. [ЗГМ]








МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ?

Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг мөнгө угаах гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар тогтоосон.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН ХОР ХӨНӨӨЛ

Үлэмж хэмжээний эд хөрөнгө эдийн засгийн үндэслэлгүй улс дамнан шилжих нь зарим улс орон, тэр ч бүү хэл бүс нутгийн санхүү, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд асар их хор уршигтай. Хууль ёсны эргэлтэд орж угаагдсан мөнгө зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмын санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үржил шимтэй хөрс нь болдог байна. Мөн шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагддаг төдийгүй санхүүгийн байгууллагын хүчин чадлыг доройтуулдаг аж. Эдгээрээс гадна улсын төсөвт орох орлого буурч, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироодог байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
1.42%	1.42%	1.10%	0.32%	0.26%	0.92%	1.11%	0.55%